

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ СОНГУУЛИЙН БҮРЭН  
ЭРХИЙН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ**  
/2015 оны жилийн эцсийн байдлаар/

Д/д	Хөтөлбөрийн заалт	Хариуцах хэлтэс, албад	Хэрэгжилтийн явц	Хувь
Нэг. Дүүргийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ. 1.1. Бизнес эрхлэгчдийг дэмжих талаар				
1.	1.1.1. Зээлийн барьцаа, батлан даалтын хуулийг хэрэгжүүлэхэд дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн үйл ажиллагааг чиглүүлнэ.	ХҮХ, ЖДҮДТ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 55 дугаар захирамжаар Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих мэдээлэл сургалтын төвийг шинээр 11 хүний орон тоотой байгуулан өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа, сургалт, холбогдох мэдээ, мэдээллээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус төв нь 2013-2015 онд 44 удаагийн сургалтанд нийт 1328 иргэнийг хамруулсан. Шинэ зуун ТББ-тай хамтран инкубатор төвийг байгуулж 34 үйлдвэрлэл эрхлэгчийг түрээсийн хөнгөлттэй ажлын байраар ханган ажиллаж байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл, олон улсын болон төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлж буй бичил зээлийн хөтөлбөрт 117 жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн 3.1 тэрбум төгрөгийн төслийг холбогдох байгууллагуудад уламжилснаас 109 иргэн, аж ахуй нэгж нь 1.7 тэрбум төгрөгийн зээлд хамрагдан төсөл нь амжилттай хэрэгжиж байна. “Хувираа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 5, 10 сая төгрөг хүртэлх жижиг зээлийн төсөлд хамрагдсан нийт 54 иргэнд 281.8 сая төгрөгийн зээл олгогдсон байна. 3.0 сая хүртэлх төгрөгийн “Санхүүгийн дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 123 иргэн 144.7 сая төгрөгийн дэмжлэг авсан. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл сургалтын төвөөр дамжуулан үйлдвэрлэл эрхлэгч 56 иргэнийг 1 тэрбум 25 сая төгрөгийн төслийг холбогдох санхүүгийн байгууллагад шилжүүлснээс жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд 11 үйлдвэрлэл эрхлэгч 1.5 тэрбум төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 43 үйлдвэрлэл эрхлэгч 129 сая, Вишнфанд банк бус санхүүгийн байгууллагаас 4 үйлдвэрлэл эрхлэгч 46 сая төгрөгийн зээлд тус тус хамрагдан төслөө хэрэгжүүлж байна. Бизнесээ тогтвортой эрхлэх	67.5

			нөхцлийг бүрдүүлэх, үйл ажиллагааг нь тогтмолжуулах зорилгоор анхан шатны сургалтанд хамрагдаж, бүлэг байгуулсан өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 31 иргэнд Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 30 гаруй сая төгрөгийн үнэ бүхий оёдол, сүлжмэл, эсгий, гар урлалын төрөлжсөн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж олгон, өрхийн үйлдвэрлэгч 54 иргэнийг Драгон худалдааны төвд байнгын борлуулалтын 4 цэгээр хангасан.	
2.	1.1.2. Аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх сургалт, бизнес инкубаци болон төсөл хөтөлбөр боловсруулах зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний дэмжлэг үзүүлнэ.	ХҮХ, ЖДҮДТ	Мэргэжлийн болон бизнесийн шат дараалсан сургалтанд 2013 онд 1536, 2014 онд 1165, 2015 онд 771, нийт 3472 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвд 37 бойжигч түрээсийн хөнгөлттэй нөхцлөөр үйл ажиллагаагаа явуулж нийт 54 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна. “Би Жи Сервис” ХХК-д 5, “Хүний эрх, хүний хөгжил” ТББ-д 2, “Технож” бизнес инкубатор төвд 4 нийт 11 бойжигч бойжуулан ажиллаж байна. 31-р хорооны нутаг дэвсгэрт “Шинэ зуун гэр хороолол” ТББ-ын байранд бойжуулах төвийг байгуулан 3 ээлжээр 34 үйлдвэрлэгчийг /73,5 м2 талбай бүхий/ түрээсийн хөнгөлттэй байраар ханган ажиллаж байна.	67.5
3.	1.1.3. Дүүргийн эдийн засгийн тэргүүлэх 5 чиглэл болох сүү, мах, барилгын материал, сүлжмэл, оёдол, гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг дээрх салбарт чиглүүлж, дүүргийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно.	ХҮХ, ЖДҮДТ	2013 онд урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамрагдахаар 70 жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүд 3.9 тэрбум төгрөгийн төсөл ирүүлснээс төсөл сонгон шалгаруулах дүүргийн дэд комисс 15 иргэн, аж ахуйн нэгжийн 550.0 сая төгрөгийн төслийг шалгаруулан холбогдох санхүүгийн байгууллагад шилжүүлэн 13 иргэн, аж ахуйн нэгж 550.0 сая төгрөгийн зээлд хамрагдан төслөө хэрэгжүүлж байна. Нийслэлийн “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 2014 онд сүүний чиглэлийн “50 үнээний цогцолбор барилга”-ын техник эдийн засгийн үндэслэлийг Улаанбаатар хотын Ерөнхий архитектороор батлуулсан. Дүүргийн Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны А/80 дугаар тогтоолоор батлуулсан. Тус ажлын хүрээнд Эрчимжсэн мал аж ахуйн цогцолбор ферм байгуулахаар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны А/79 дүгээр тогтоолоор 21-р хорооны Нарийны хөндийн “Шар хоолойн ам”-нд 500 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авлаа. Дүүргийн Бренд бүтээгдэхүүнээр 2014, 2015 оны “Шилдэгийн шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр 2, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр 4, “Дэвшилтэт технологиор үйлдвэрлэсэн шилдэг бүтээгдэхүүн”-ээр 1, “Өргөн хэрэглээний шинэлэг шилдэг бүтээгдэхүүн”-ээр 1, ЭКО үйлдвэрлэлийн аргаар барилгын материал болон	67.5

			бусад бүтээгдэхүүнээр 1, дүүргийн Бренд бүтээгдэхүүнээр “Миний монголын сүү”, “Цацрагийн хамгаалалт” шалгарсан. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/458 дугаар захирамжийн дагуу “Дүүргийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын зөвлөл”-ийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зөвлөлийн хурлаар дотоод журмыг хэлэлцэн баталлаа. Тус салбар зөвлөл дүүргийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг холбогдох хууль, журам, хөтөлбөрийн хүрээнд чиглүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.	
4.	1.1.4. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.	ХҮХ, ЗХХ	Хамтын ажиллагаатай дүүрэг болох ӨМӨЗОрны Хөлөн буйр аймгийн Хайлаар, БНХАУ-ын Эрээн хот, Мишээл экспо төвд зохион байгуулагдсан 2014 оны олон улсын үзэсгэлэн худалдаанд оёдол, сүлжмэл нэхмэл, гар урлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг зохион байгуулан оролцуулсан. Япон Улсын Фарм Дү компани, Эвридэй ХХК-ний 50, 50 хувийн хөрөнгө оруулалтаар 21-р хороо Дааган толгойд гүзээлзгэний тариалалт, үйлдвэр бий болгоход зориулж 23 га газрыг шийдвэрлэн амжилттай хэрэгжиж байна. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/262 дугаар захирамжийн дагуу Хайлаар хотод зохион байгуулагдсан Хятад, Монгол, Орос гурван улсын Эдийн засгийн форум, үзэсгэлэн яармаг худалдаанд жижиг, дунд үйлдвэрлэгчдийн төлөөлөл 15 иргэнийг оролцуулсан. Оролцогчид 48.0 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүний борлуулалт хийсэн байна. Арга хэмжээний үеэр жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг Хайлаар хотод борлуулах “Сонгинохайрханд үйлдвэрлэв” худалдааны цэг нээх тухай Санамж бичигт гарын үсэг зурлаа. “Санамж бичиг”-ийн хүрээнд дүүргийн үйлдвэрлэгчид Хайлар хотын Нантун худалдааны төвд 9-11-р сард ноос, ноолуурын чиглэлээр 1 лангуу ажиллуулан бараа бүтээгдэхүүнээ худалдаалсан. 11-р сараас эхлэн Манжур хотын худалдааны төвд байнгын борлуулалтын цэг нээн ажиллуулж байна.	67.5
5.	1.1.5. Газар тариалан, төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	ХҮХ, ӨГХА	2013 онд “Шинэлэг санаан дээр суурилсан хүнсний аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд “Каритас-монгол” ТББ-аас 46 хүлэмж, 29 зоорийг барьж байгуулан дүүргийн нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 75 иргэнд хүлээлгэн өгсөн. Хүлэмж, зоорины аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр “Хүлэмжийг хэрхэн ашиглаж сурах, зоорийг яаж бий болгох, түүнийг ашиглах нь” сэдэвт сургалтуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 3 удаа 280 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулсан. Дүүргийн газар тариалан	75.0

			<p>эрхлэгчдийн зөвлөгөөнийг нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газартай хамтран 2014 онд 21-р хороо 361 гарамын “Их булгийн тохой” ХХКомпаний тариалангийн талбайд зохион байгуулсан. Тус зөвлөлгөөнд 150 гаруй иргэд, 10 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцсон. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/83 дугаар захирамжаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэлтийг нэмэгдүүлэх, практик сургалт, чацаргана, жимс жимсгэнэ, таримал ургамлуудад түгээмэл хэрэглэгдэж буй усалгааны системийг хэрхэн ашиглах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх танхимын болон талбайн сургалт, Өрхийн тариаланг механикжуулах зорилгоор жимс, жимсгэнэ, хүнсний ногооны иж бүрдэл техникийн үзүүлэх сургалтуудыг Их булгийн аманд зохион байгуулж нийт 200 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдлаа. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас зарлагдсан “Жимс, жимсгэний плантаци байгуулах” төсөлд дүүргийн “Таримал загийн төгөл” ХХКомпани шалгарлаа. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг 5 цэгт зохион байгуулсан. Эх орны хөрсөнд ургасан эрүүл ахуйн шаардлага хангасан хямд үнэтэй төмс, хүнсний ногоог тариаланчдын гар дээрээс үнийн нэмэгдэлгүй худалдан авах боломжийг бий болгосон.</p>	
6.	1.1.6. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	ХҮХ	<p>“Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн газар нутгийг шинэчлэн тогтоох тухай” дүүргийн Засаг даргын 2013 оны 121 дүгээр захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг 3 аж ахуйн нэгжийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор үйлчилгээ үзүүлэх газар нутгийн заагийг шинэчлэн тогтоов. Нийслэл, дүүргээс малчдын дунд авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг танилцуулах, хэрэгжилтийг хангах, малын хулгайн гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Малчдын зөвлөгөөн”-ийг 2013 оны 3-р сард Жаргалант тосгонд зохион байгуулсан. Малыг удмын санг хамгаалах ажлын хүрээнд мал, амьтдыг вакцинжуулах ажлын зардалд нийт 59.4 сая төгрөг зарцуулсан байна. Нийт 11400 бод ээмэгжүүлэхээс 11180 бод, 8000 бог ээмэгжүүлэхээс 100 хувь ээмэгжүүлэн нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын мэдээллийн санд оруулсан. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас жил бүр зохион байгуулдаг “Шилмэл мал” үзэсгэлэн худалдааг 2013, 2014 онд Хүй долоон худагт, 2015 онд Яармагийн дэнжид тус тус зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаанд мал аж ахуйн салбарт ажлын амжилт гарган, малын үүлдэр угсааг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэн нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангахад үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж</p>	67.5

			байгууллагуудыг шалгаруулж дүүргээс тэргүүн байр 3, дэд байр 1, сүүний чиглэлийн шилмэл хээлтүүлэгч 2, шилдэг хээлтэгч 3, 2014 онд Түмэн-үхэрт хоршоо нь Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны хүндэт өргөмжлөлөөр тус тус шагнууллаа. Мөн Улсын тэргүүний фермер 2, Нийслэлийн тэргүүний фермер 5, Нийслэлийн тэргүүний сайн малчин 1, Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон 1 тус тус шалгарлаа. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд тус дүүргийн 21-р хороонд нийт 6 худаг гаргасан	
7.	1.1.7. Худалдаа, нийтийн хоол, аялал жуулчлал, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	ХҮХ, МХХ,ЦХ I, II хэлтэс	Дүүргийн нутаг дэвсгэрт худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад аттестатчилах, удирдамжит, төлөвлөгөөт, нэгдсэн арга хэмжээ, түүвэрчилсэн гэнэтийн хяналт шалгалтуудыг 2013-2015 онуудад давхардсан тоогоор 1641 гаруй байгууллагыг хамруулан 15 удаа явууллаа. Нийт 402 зөрчил илрүүлэн, 115 аж ахуйн нэгж, иргэний 2659ш тамхи, 89 шил архийг тус тус хурааж улсын орлого болгосон.Зөрчил гаргасан 151 аж ахуйн нэгж, иргэнд 12,1 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулан, 61 заалт бүхий 16 албан шаардлага өгч зөрчлийг арилгуулж ажиллаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналтын системийг боловсронгуй болгож, камержуулалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд худалдаа үйлчилгээний байгууллагуудын 80 хувь нь гадна орчныг, 100 хувь дотоод орчныг хянах камерыг суурилуулсан байна. 2013-2015 онуудад аттестатчиллаар стандартын шаардлагыг 85%-иас дээш хангасан, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан, тохижилт, ногоон байгууламжийг тодорхой түвшинд нэмэгдүүлсэн худалдааны 780, нийтийн хоолны 223 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг сунгах, эрх сэргээх, шинээр олгох, стандарт шаардлага хангаагүй худалдааны 141, нийтийн хоолны 51 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлах шийдвэрийг ЗАА-нд уламжлан шийдвэрлүүлсэн. 2013-2015 онуудад дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 420 аж ахуйн нэгж байгууллагуудад 11 удаагийн давхардсан тоогоор хяналт шалгалтуудыг явууллаа. Хяналт шалгалт хийх явцад 53 албан шаардлага өгч, зөрчил гаргасан 15 аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэнд нийт 4.4 сая төгрөгний торгуулийн арга хэмжээг авлаа. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/180 дугаар захирамжийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбай, явган зорчигчийн зам дээр зөвшөөрөлгүй байрлах нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан ТҮЦ, чингэлэг, павильонуудыг албадан чөлөөлөх зорилгоор хяналт шалгалтыг	75.0

			явууллаа. Хяналт шалгалтаар 23 иргэнд албан шаардлага хүргүүлж, 18-р хорооны Залуус хороололд зөвшөөрөлгүй байрлах 3 чингэлэг, 21-р хорооллын автобусны буудлын дэргэдэх 2 чингэлэг, Өнөр хорооллын Замын цагдаагийн тасгийн дэргэд байрлах 1 чингэлэг, Драгон төвийн дэргэдэх 2 чингэлэг, Цамбагарав ,Саппоро үйлчилгээний төвийн урд байрлах 4 чингэлэгийг Өмч газрын харилцааны албаны журмын хашаанд нүүлгэн газрыг чөлөөллөө. Нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран 8 амралт, жуулчны бааз, гэр буудалд стандартын үзлэг шалгалтыг явуулахад стандартын шаардлага хангасан-3, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн-3, шаардлага хангаагүй-2 аж ахуйн нэгж байна. Нийслэлийн 2015 оны шилдэг тохижилт, ногоон байгууламжтай цэмцгэр байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулах болзолт уралдааны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн ахуйн үйлчилгээний 200 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд удирдамж, ном тарааж, мэдээлэл хийж, тохижилтын шинэлэг санаа, санаачлагын талаар аргачлал, зөвлөлгөө өгч хяналт тавьж ажиллалаа. Болзолт уралдааны хүрээнд аж ахуйн нэгж, иргэдийн 60 гаруй хувь нь тохижилт бүтээн байгуулалтыг сайн хийж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна. Нийслэлийн шилдэг тохижилттой халуун усны газраар 5-р хороо “Чандмань” халуун усны газар шалгаран өргөмжлөл 5 сая төгрөгөөр шагнагдсан.	
8.	1.1.8. Толгойт, Баянхошуу, Өнөр бүсүүдэд стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны худалдаа, үйлчилгээний цогцолбор төв байгуулах санаачлагыг дэмжинэ.	ХҮХ	Үүрт гоулд ХХК 20-р хорооны Хүнс трейдийн ард байрлалтай өөрийн эзэмшлийн газарт Толгойт бүсийн ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээг ойртуулах зорилгоор худалдааны цогцолбор барих хүсэлт ирүүлснийг судлан, нийслэлийн Өмч харилцааны албанд хандаж, хот төлөвлөлтийн судалгаанд хамрагдаж, зөвшөөрөл авах тухай зөвлөлөө. 1-р хороонд Алтан жолоо импекс ХХК худалдааны цогцолбор ложистик төв, 7-р хорооны Цэнгэл таван ихэр ХХК-ний Сувдан төв, 9-р хорооны Шар нуурын мандал ХХК-ний GMG төв, 20-р хороонд Бишрэлт трейд ХХК, 32-р хорооны нутаг дэвсгэрт Макс хүнс ХХК, Номин тав трейд ХХК-иуд 30-70 гаруй хүний ажлын байр бий болгож, цэг салбараа өргөтгөсөн. 2015 онд Сайхан монгол ХХК нь 20-р хорооны нутаг дэвсгэрт Толгойт бүсийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад худалдаа, үйлчилгээг ойртуулж, 500 гаруй хүнийг ажлын байраар хангасан, орчин үеийн шийдэлтэй хүнс, барааны Сэлэнгэ захыг, 22-р хорооны нутаг дэвсгэрт Хос ай таг ХХК, Анхны хишиг ХХК, Энх мөнх хүсэл ХХК-иуд 80 гаруй хүнд ажлын байр бий болгож, орчны тохижилт, үйлчлүүлэгчийн тав тух, стандартын шаардлагыг хангасан худалдааны	75.0

			цогцолбор төвүүдийг ашиглалтанд оруулсан үйл ажиллагааг дэмжин холбогдох зөвшөөрлийг олгож, гэрээ байгуулан ажиллаа.	
9.	1.1.9. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.	ХҮХ	<p>Стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон 32 хорооны 172 /давхардсан тоогоор/ цэгээр нөөцийн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан. “Өрх бүрт нэг гулууз” нөөцийн махны өргөтгөсөн худалдааг 2013 онд 5 удаа, 2014 оны 06 дугаар сар хүртэл, 2015 оны 4 сар хүртэл 7 хоног бүрийн Баасан, Бямба, Ням гарагуудад зохион байгуулсан. Нөөцийн махны борлуулалтын явцад мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран хяналт шалгалтыг тогтмол зохион байгууллаа. Хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хүлэмж, зорины ашиглалт, хамгаалалтанд хяналт шалгалтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа. Хяналт шалгалт нийт 42 /давхардсан тоогоор/ иргэн, аж ахуйн нэгж хамрагдсанаас зөрчил дутагдалтай аж ахуйн нэгжүүдэд 8 заалт бүхий 12 “Зөвлөмж”, 1 “Албан шаардлага”-ыг хүргүүлж гүйцэтгэлийн хяналт хийснээр 3 аж ахуйн нэгж ихээс дунд, 5 аж ахуйн нэгж, иргэн дундаас бага эрсдэлтэйрүү шилжсэн ба улсын байцаагчийн хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг хугацаанд нь ирүүлээгүй 2 албан тушаалтанд тус бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх торгуулийн арга хэмжээ, шийтгэвэр ногдуулан бүрэн барагдуулсан байна. “Эрүүл хүнс, зөв зохистой хооллолт, тэжээлийн дутлаас урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт сургалт, хоолны өдөрлөгийг 79, 156, 105, 106-р цэцэрлэгийн тогооч, багш нар болон 290 гаруй эцэг эхчүүдийн төлөөллийг оролцуулан “Хүүхдийн хоол тэжээл-Эрүүл мэнд” сэдэвтэй сургалт, амталгаат хоолны өдөрлөгийг Технологийн дээд сургууль, Хүнс хангамж улсын үйлдвэртэй хамтран тус тус зохион байгууллаа</p> <p>Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Хоол шим тэжээлийн төв дээр “Эрүүл аюулгүй хүнс, зөв зохистой хооллолт, хүнсний аюулгүй байдал” сэдэвтэй сургалтыг 49 тогооч, менежер нарыг хамруулан зохион байгуулсан. “Хүнсний аюулгүй байдал”-ын талаарх сургалтыг Кристал ресторанд МХХ, Дэлхийн банк групптэй хамтран хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгууллаа. Сургалтын үеэр хоол үйлдвэрлэлийн бизнес эрхлэгчдэд зориулсан багц зөвлөмжийг тарааллаа. Сургалтанд 34 нийтийн хоолны газрын төлөөлөл хамрагдлаа.</p>	75.0
10.	1.1.10. Архи, тамхины болон эрүүл бус хүнсний хэрэглээг	ХҮХ	Дүүргийн Засаг даргын А/158 захирамжийн дагуу “Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх сарын аян”-ыг зохион байгууллаа. Аяны	67.5

	<p>бууруулах бүх нийтийн аян өрнүүлэх замаар эрүүл, соёлтой үйлчилгээ үзүүлдэг бизнесийн байгууллагыг дэмжинэ.</p>	<p>хүрээнд Тамхины хяналтын тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх сургалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн хуулийн төслийн хэлэлцүүлгийг Баянхошуу, Толгойт бүсэд худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг 250 аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж, тамхи татахыг хориглосон анхааруулах материалыг сургалтанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлд тараасан. Дүүргийн Засаг даргын 2013 оны 352, 2014 оны А/279 дугаар захирамжийн дагуу дүүргийн шилдэг рестораныг шалгаруулж Засаг даргын Өргөмжлөлөөр шагналаа. НЭМГ-аас 2013 оны Нийслэлийн шилдэг “Эрүүл зөв хоолыг эрхэмлэгч ресторан”- аар “Дархан хүч” Комплекс ХХК-ны Кристал ресторан, 2014 онд “Эрдэнэчулуут ХХК-ны “Одод” ресторан, Д. Батжаргал ХХК-ны “Бродвэй” ресторануудыг тус тус тэргүүн байраар шалгаруулсан. Дүүргийн “Архигүй Баасан гараг” дэд хөтөлбөрийн хүрээнд “Сүүтэй бялуутай үдэш” аяныг Цамбагаравын Рокси диско бааранд зохион байгууллаа. Нээлтийн ажиллагаанд дүүргийн удирдлагууд оролцож архи, тамхины хор, хөнөөлийн талаар илтгэл тавилаа. “Сүүтэй, бялуутай үдэш” үйл ажиллагаанд Мандах дээд сургуулийн 60 оюутан, багш нар оролцлоо. Тус аяны тугийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 8 аж ахуйн нэгжээр аялуулан идэвхи, санаачлагатай оролцсон Баясах-Оюу ХХК-ны Рокси баар, Тэнгэрлэг интернешнль ХХК-ны Вест баарууд шилдэгээр шалгарч Засаг даргын өргөмжлөлөөр шагнав. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/183 дугаар захирамжийн дагуу “Архи, тамхины хор хөнөөл”-ийг сурталчлах аяны хүрээнд дүүргийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газруудад “Архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах болон Аюулгүй хүнс зөв зохистой хооллолт” сэдэвт сургалтыг Шинэ Драгон ресторан болон Одод ресторанд тус тус зохион байгууллаа. Сургалтанд нийт 255 нийтийн хоолны газрын төлөөлөл хамрагдлаа. Архи, тамхины хор хөнөөлийг хүүхэд, залуучуудад ойлгуулан таниулах зорилгоор Толгойт, Төв, Өнөр, Баянхошуу бүсүүдийн 12, 65, 86, 105-р ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 563 сурагчдад “Архи, тамхины хор хөнөөл”-ийг сурталчлах аяныг зохион байгууллаа. Аяны үеэр архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах зорилгоор “Архины хор нөлөө”, “Спиртлэг бус Спортлог” амьдралын төлөө хамтдаа, “Тамхи таны эрүүл мэндийн дайсан” сэрэмжлүүлэг, гарын авлага материал хэвлүүлэн тарааж, дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран сургалт зохион байгууллаа.</p>	
--	--	--	--



11.	1.1.11. Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэн өмчилсөн газраа эдийн засгийн эргэлтэнд оруулахад дэмжлэг үзүүлнэ.	ӨГХА	Нийслэлийн Засаг даргын 48 удаагийн захирамжаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 15396, илүү талбайгаа үнээр авсан 25, хамтран өмчлөгч хасуулсан болон кадастрын зураг өөрчлөгдсөн 2124 иргэний буюу нийт 17545 иргэний газар өмчлөлийн асуудлыг шийдвэрлэсэн. 24-р хороо Баруун салааны зуслан, 25-р хороо Зүүн салааны зусланд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг эхлүүлэхээр нийслэлийн Өмчийн харилцааны газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгүүлэх талаар санал хүргүүлсэн.	75.0
12.	1.1.12. Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг ойртуулна.	ХҮХ	2013 онд Ахуйн үйлчилгээг иргэдэд ойртуулах ажлын хүрээнд Нарта ХХК-ын гаргасан хүсэлтийг дэмжин хими цэвэрлэгээний 15 түргэн үйлчилгээний цэгийг байршуулж, гэрээ байгуулан ажилласан. 30, 31-р хороонд НҮБ-ийн ХАБИТАТ төслийн хөрөнгөөр ахуйн үйлчилгээний төв баригдсаныг ашиглалтанд хүлээн авсан. Монголын үсчин гоо засалчдын холбооны харьяа “Оюунлаг хатад” сургалтын төв дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй 80 иргэнийг үсчин гоо засалч, гар урлалын чиглэлээр мэргэжлийн сургалтанд хамруулан ажлын байраар хангасан. Мөн Цэнгэл сор ХХК-ны “Зулаа” сургалтын төв 42 иргэнийг үсчин, гоо засалчийн мэргэжлийн сургалтанд хамруулан ажлын байранд зуучилсан. 2014 онд дүүргийн ахуйн үйлчилгээ эрхлэгчдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй 2 жилийн хугацаатай, жилийн 10,2 хувийн хүүтэй 5.5 сая төгрөгийн зээл олгож, “Аж ахуй эрхлэлтийн хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд оёдлын үйлдвэрийн чиглэлээр 37,5 сая, дархан 1.0 сая, саун 1.0 сая, гэр ахуйн тавилга үйлдвэрлэлийн чиглэлээр 7.0 сая, үсчин 7.0 сая, гар утас 5.0 сая, халуун усны чиглэлээр 1.0 сая, гутал үйлдвэрлэлийн чиглэлээр 11.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгосон. Мөн ЖДҮХС-гийн хөнгөлөлттэй зээлд халуун усны чиглэлээр 75.0 сая, оёдлын чиглэлээр 105.0 сая, гэр ахуйн тавилга үйлдвэрлэлийн чиглэлээр 110.0 сая, алт мөнгөний дарханы чиглэлээр 20.0 сая төгрөгийн зээлийн санхүүжилт олгохоор дэмжлэг үзүүлсэн. ЖДҮДТ-д дүүргийн ахуйн үйлчилгээ эрхлэгч 11 иргэн, аж ахуйн нэгж байгууллага бойжуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг 100%-ийн хөнгөлөлттэйгээр олгосон. 32-р хороонд ахуйн үйлчилгээний төв барихаар ажиллаж байгаа “Арвайн төгөл” ХХК-д ЖДҮХС-гийн 40.0 сая төгрөгийн хөнгөлөлт зээл олгосон. “Нийслэлийн хэмжээнд үнэт металл, алт мөнгөний дарханы үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд аттестатчилал явуулах	75.0

			<p>тухай” удирдамжийн дагуу Стандарт хэмжил зүйн газартай хамтран 2014 онд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээ эрхлэгч 13 аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт явуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. 2015 онд дүүргийн 3, 7, 22-р хороодод шинээр халуун усны газар байгуулах 3 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч гэрээ байгуулсан. Дүүргийн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн дунд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”, ахуйн үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй журам стандартыг сурталчилан таниулах чиглэлээр 4-р сард дүүргийн иргэний танхимд 30 гаруй аж ахуйн нэгжийг хамруулан сургалт зохион байгуулсан.</p>	
<b>1.2. Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын талаар</b>				
13.	1.2.1. Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, дүүргийн эдийн засгийн хөгжлийг сайжруулна.	СТСХ, ТХ	<p>2013 оны гүйцэтгэлээр :</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын төвлөрсөн төсөвт 25117.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 25877.3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.0 хувь</li> <li>- Нийслэлийн төсвийн орлогод 15893.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 16766.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 105.0 хувь</li> <li>- Орон нутгийн төсвийн орлогод 5339.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 6644.2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 124.0 хувиар тус тус биелэсэн.</li> </ul> <p>2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр :</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсөвт 32467.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 31387.9 сая төгрөг төвлөрүүлж 96.6 хувь</li> <li>-Нийслэлийн төсөвт 22317.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 21825.1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 97.7 хувь</li> <li>- Орон нутгийн төсөвт 6805.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 6908.2 сая төгрөг төвлөрүүлж төсвийн орлогын төлөвлөгөөг 101.5 хувиар тус тус биелүүлэхээр байна.</li> </ul> <p>2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Улсын төвлөрсөн төсөвт 26216,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 23590,8 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 90,0 хувь</li> <li>- Нийслэлийн төсвийн орлогод 23399,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 21069,4 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 90,0 хувь</li> <li>- Орон нутгийн төсвийн орлогод 7843,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 7183,2 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 92,0 хувиар тус тус биелүүлэхээр байна.</li> </ul> <p>Дүүргийн хэмжээнд 2013-2015 онуудад улс, нийслэл, дүүргийн төсвийн</p>	75.0

			хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалт гарган мэдээллийн сан үүсгэн ажилласан. Үүнд: улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 11,8 тэрбум төгрөг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 31,8 тэрбум төгрөг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 3,5 тэрбум төгрөг, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,4 тэрбум, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн дүн мэдээтэй байна. 2013-2015 онуудад хийгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг хороо тус бүрээр гаргаж мэдээллийн сан үүсгэсэн.	
14.	1.2.2. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар өөрийгөө тэтгэх эдийн засагтай болох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, цаашдаа төсвөөс авах татаасыг бууруулах чиглэлд бодлогыг уялдуулна.	СТСХ, ТХ, СХ	<p>2013 оны гүйцэтгэлээр :</p> <p>Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх замаар өөрийгөө тэтгэх эдийн засагтай болох хөтөлбөр боловсруулах бэлтгэл ажлыг ханган, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүү эдийн засгийн ажлын хэсэгтэй хамтран ажилласан. Энэхүү ажлын хүрээнд “Ажилтай, орлоготой Монгол хүн” дэд хөтөлбөр, ”Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний дэд хөтөлбөр, ”Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөрүүдийг Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, хариуцах хэлтэс албадуудтай хамтран хэрэгжүүлэн ажилласан. Тус дүүргийн төсвийн орлогод рекламны самбарын орлогыг төлөвлөн оруулдаг болсон, дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа элс хайрга, шар шаварны карьерүүдийн лицензний сунгалт буюу түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиг төлбөрийн орлого, Монгол улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтануудад төлөвлөгөө хуваарилан өгөх замаар дүүргийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажилласан.</p> <p>2014 онд :</p> <p>Дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг хөтөлбөртэй холбогдуулан холбогдох газруудаас санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Бэлтгэл ажлын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд эд хөрөнгө худалдан борлуулсаны тэмдэгтийн хураамжийг СБД-н татварын албанд төвлөрүүлдэг байсныг болиулж СХД-н татварын хэлтэст төвлөрүүлдэг болсон.</li> <li>2. Дүүргийн Засаг Даргын 2014 оны 06-р сарын 06-ны өдрийн А/194 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2014 оны 08-р сарын 01 хүртэлх хугацаанд дүүргийн бүх хороодын аж ахуйн</li> </ol>	37.5

			<p>нэгжүүдээр явж ус рашаан ашигласны гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>3. Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс үзүүлдэг болсонтой холбогдуулан Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлд тус тус заасны дагуу эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг уг бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй нутаг дэвсгэрийн татварын байгууллагын дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.</p> <p>Мөн дүүргийн ИТХ-ын тогтоолоор түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлдөг аж ахуйн нэгж байгууллагуудад үзлэг шалгалт хийж төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаа.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2015 оны А/43 дугаар захирамжаар дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн дүүргийн Засаг даргын орлогч Ганаагаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Мандах нягтлан бодох дээд сургуулийн эрдэмтэн багшийг оруулан суурь судалгааны ажил хийж байсан боловч ажил зогссон.</p>	
15.	1.2.3. Төсвийн болон Татварын хууль тогтоомжийг сурталчлах, байгууллага, иргэнийг татварт бүрэн хамруулах, татварын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, өр барагдуулах менежментийг боловсронгуй болгоно.	СТСХ, ТХ	<p>Татварын хууль тогтоомжийг сурталчлах, татвар төлөгчдийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 2013 оны байдлаар давхардсан тоогоор нийт 1000 гаруй аж ахуйн нэгж, 4217 иргэнд сургалт хийж, зөвөлгөө өгсөн Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Татварын ерөнхий газрын дарга нарын 2013 оны 9 дүгээр сарын 16-ний өдрийн 2/866/03 тоот хамтарсан захирамж тушаал, Дүүргийн засаг даргын 382 дугаар захирамжийн дагуу тус дүүргийн нутаг дэвсгэр дээр Үл хөдлөх эд хөрөнгийн тооллого, татвар төлөгч иргэнийг бүртгэлжүүлэх ажлыг нэг сарын хугацаатай зохион байгуулсан. 2013 оны 09-р сарын 24-өөс 11-р сарын 01-ыг хүртэлх хугацаанд бүртгэлд объект, үл хөдлөх эд хөрөнгө 15886, газар 3616, ажлын байр 3140 хамрагдсан. Тооллогын явцад шинээр нэмж илрүүлсэн ажлын байр 141, объект үл хөдлөх хөрөнгө 66 бүртгэгдсэн. Энэ нь цаашид үл хөдлөх хөрөнгийн татвар ногдуулалтыг нэмэгдүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр болсон. 2012 оны эцсийн байдлаарх хяналт шалгалтын 1.9 тэрбум төгрөгийн өрнөөс 858.3 сая төгрөгийн өр барагдуулж 44.2 хувиар биелсэн. Тайлант хугацаанд хяналт шалгалтаар 731 татвар төлөгчид 4.0 тэрбум төгрөгийн акт тавигдсанаас 2.2 тэрбум төгрөгийн өр барагдуулж 55.0 хувиар биелсэн. Нийт 29 удаагийн сургалт</p>	67.5

		<p>сурталчилгаа зохион байгуулж утсаар болон бичгээр 17401 иргэн аж ахуйн нэгжид сурталчилгаа, 18 602 иргэн аж ахуйн нэгжид зөвлөгөө өгсөн байна. 2014 онд 624 аж ахуйн нэгж, 35 хувь хүнтэй холбоотой шалгалт хийж 2.4 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулан төлүүлэхээр акт тогтоож 860.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна.</p> <p>2015 онд:</p> <p>Татвар төлөгчдийг төлөвшүүлэх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор дараах сургалтуудыг зохион байгууллаа.</p> <p>-Татвар төлөгчдийг төлөвшүүлэх, татварын хуулийг сурталчлан таниулах зорилгоор хэрэгжүүлж буй Инновацийн хөтөлбөрийн хүрээнд Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр 2015 онд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдэд "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон Цахим тайлангийн систем" сэдэвт сургалтыг сар бүрийн 5-ны өдөр зохион байгуулж хэвшин нийт 4 удаагийн сургалт зохион байгууллаа.</p> <p>- Албан татвар төлөгчөөр 2015 онд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдэд "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Цахим тайлангийн систем" сэдэвт сургалтыг сар бүрийн 10-ны өдөр зохион байгуулж хэвшин нийт 4 удаагийн сургалт зохион байгууллаа.</p> <p>-Татварын ерөнхий газартай хамтран татварын тайлангаа хоцроосон, татварын албанаас тайлан нь буцаагдсан 210 татвар төлөгчийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн сургалтанд хамрууллаа.</p> <p>- Татвар төлөгчдийн өдрүүдээр дүүргийн 32 хорооны Иргэний танхимаар дамжуулан "Иргэдээ сонсьё" сургалтууд зохион байгуулж, 920 гаруй татвар төлөгчдийг хамран тэдний гаргасан санал хүсэлтийг ил захидлаар хүлээн авч нэгтгэн,нийслэлийн Татварын газарт хүлээлгэн өгч санал бодлоо солилцлоо. 2014 оны жилийн эцсийн өр барагдуулах ажлын хүрээнд Хяналт шалгалтын тасаг өр барагдуулахаар өрийн насжилтын судалгааг шинэчлэн гаргаж, эрчимжүүлсэн ажлын төлөвлөгөөг гарган ажилласан. 2015 онд шалгалтанд 344 аж ахуйн нэгж хамрагдаж 1,1 тэрбум төгрөгийн төлбөр тавигдсан. Үүнээс 707,3 сая төгрөгийг барагдуулаж, хүү торгуульд 349,5 сая төгрөгний акт тавигдсанаас 242,5 сая төгрөгийг барагдуулсан болно. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх,тэдгээрийн хяналтыг сайжруулах үүднээс Эмээлт, Хангай зах, Шөнийн зах, Драгон зах, Эгүшин, Жанцан, Сувдан худалдааны төвүүдэд 2015 оны 3-р сараас 11-р сарын 25 хүртэл татварт хамрагдаагүй иргэдийг</p>	
--	--	---	--

			татварт хамруулах ажлыг зохион байгуулж ажиллаа. Энэхүү ажлын хүрээнд 144 иргэнээс 21989,0 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.	
16.	1.2.4. Аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан тушаалт, тендерийн сонгон шалгаруулалт, үр дүн зэрэгт хүний оролцоог багасгаж, 100 хувь цахим тогтолцоог нэвтрүүлнэ.	СТСХ, ТХ, ХААА	<p>2013 оны гүйцэтгэлээр :</p> <p>Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 2012 оны жилийн эцэс, 2013 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайланг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Тайлан тушаалт 74.2-88.0 хувьтай байсан. Цаашид аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайлан тушаалтыг тоон гарын үсэгт шилжүүлэх ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласанаар санхүүгийн тайлан 100 хувь цахим хэлбэрт шилжсэн. 2013 оны 3-р улирлын байдлаар 9306 аж ахуйн нэгж байгууллага тайлан тушаахаас 7492 байгууллага тушааж, тайлан тушаалт 80.5 хувьтай байсан. 2013 онд дүүргийн төсөвт нийт 26600.0 мянган төгрөгийн торгуулийн орлого оруулсан. Татварын тайланг цахим хэлбэрт шилжүүлж, аж ахуйн нэгж байгууллагуудад тоон гарын үсэг олгосонньтатвар төлөгчдийн цаг зав, хөрөнгө мөнгийг хэмнэсэн үйл явдал болсон. 2013 оны 3-р улиралд "Цахим татварын мэдээллийн систем"-ээр Онцгой албан татварын тайлан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, Цалин хөлсний- ТТ-11 тайлан, хувь хүнд олгосон орлогоос суутган тооцсон -ТТ-12 тайлан гэсэн нийт 5 төрлийн тайланг хүлээн авсан.</p> <p>2014 онд :</p> <p>Сонгинохайрхан дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 2014 оны 1, 2, 3-р улиралын санхүүгийн тайланг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулан ажилласан байна. Дүүргийн хэмжээнд нийт 10827 аж ахуйн нэгж байгууллага тайлан тушаахаас 8013 байгууллага тайлангаа цаасаар болон цахимаар тушаасан нь нийт тайлан өгвөл зохих аж ахуйн нэгжийн 78.8хувьтайтэнцэж байна. Шинээр Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн 557 аж ахуйн нэгж, 53 иргэн бүртгэсэн ба тоон гарын үсэг шинээр 2046 аж ахуйн нэгжид олгосон байна. 2014 оны эхний 10-р сарын байдлаар дүүргийн төсөвт нийт 29760.0 мянган төгрөгийн торгуулийн орлого оруулсан.</p> <p>2015 онд:</p> <p>Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулж нийтдээ 7687 тайлан хүлээн авсны 93.5 хувь буюу 7184 тайланг баталгаажуулсан. 2015 оны 1, 2, 3 дугаар улирлын тайланг цахим</p>	67.5

			хэлбэрээр хүлээн авч, тайлан тушаалт дунджаар 85.9 хувьтай байна. 2014 оны 11 дүгээр сарын байдлаар дүүргийн төсөвт 30420,0 мянган төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлсэн болно. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт ажлын 20 хувьтай тэнцэхүйц хэмжээний ажлыг цахим худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулан ажилласан. Тендерийн баримт бичгийг боловсруулан захиалагчаар батлуулах ба батлуулсан баримт бичгийг CD-нд хуулбарлан оролцогч компаниудад тарааж ажилласан.	
17.	1.2.5. Орон нутгийг хөгжүүлэх сангийн орлогыг нэмэгдүүлэх менежментийг боловсронгуй болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжинэ	ЭЗТХ	Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу 2013-2015 онд дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санал асуулгыг 3 удаа зохион байгуулахад нийт давхардсан тоогоор 98377 иргэн оролцож 483 ажлын чиглэлээр 324335 санал ирүүлснийг хөгжлийн бодлоготой уялдуулан тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн хуулийн хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдын Хуралд өргөн барьж нийт 12398,1 сая төгрөгийн өртөг бүхий 390 багц ажил хийж гүйцэтгэхээр батлуулснаас 9765,9 сая төгрөгийн өртөг бүхий 334 ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулсан бөгөөд нийт ажлын гүйцэтгэл 90%-тай байна. Улсын хэмжээнд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн эх үүсвэр багассан тодорхой шалтгааны улмаас 2014 онд 41 төсөл, арга хэмжээг зогсоосон. Тайлант хугацаанд дүүргийн ОНХС-гийн хөрөнгөөр гэрэлтүүлэг 46 байршилд 56200м, гүний худаг, усан сан 39 ш, тоглоомын талбай 36 байрлалд, иргэний танхим, чийрэгжүүлэлтийн танхимд тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 41, явган хүний зам 19 байршилд 9585 м2, автомашины зам засварлах ажил 10 байршилд 6100м, явган хүний гүүр 11ш, бичил тохижилт 22, авто зогсоол байгуулах 4 зэрэг ажлууд хийгдсэн байна. 2014 онд хөрөнгө оруулалтын ажлыг шуурхай зохион байгуулах, хяналтыг сайжруулах зорилгоор “Дүүргийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын явцад хяналт тавих, хүлээж авах журам”-ын төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны А/84 дугаар тогтоолоор батлуулсан. Уг журмын дагуу дүүргийн Засаг даргын 2014 оны А/272 дугаар захирамжаар дээрх ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээж авах комиссуудыг байгуулан мэргэжлийн инженерүүдтэй гэрээ байгуулж хөрөнгө оруулалтын ажилд тогтмол хяналт тавин ажилласан. Хяналт тавих явцад 88 зөрчил /ажлын тоо хэмжээ зөрүүлсэн, техникийн нөхцөл зөрчсөн г.м/	75.0

		<p>илрүүлэн хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцон ажилласан. Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны А/32, А/58 дугаар тогтоол, Засаг даргын Б/07 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт дүүргийн төсөв, улс, нийслэлийн зээл, тусламж, төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд болон дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг тооцох, техникийн нөхцөл авах, ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, захиалагчийн хяналтыг мэргэжлийн чиг үүргээр хэрэгжүүлэх, өдөр тутмын инженерийн хяналт тавих, улсын комиссын үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэн ажиллах чиг үүрэг бүхий ОНӨААТҮГ Захиалагчийн албыг 9 хүртэлх хүний орон тоотойгоор байгуулсан. 2015 оны 11 дугаар сарын 27-ны байдлаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих 2 тэрбум 339 сая төгрөгийн төсөвтэй 48 ажил, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 452 сая төгрөгийн төсөвтэй 3 ажил нийт 2 тэрбум 791 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 ажилд инженерийн хяналт тавин ажилласанаас 37 ажил байнгын ашиглалтанд хүлээж авсан 14 ажил он дамжин хийгдэхээр гэрээ сунгасан. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх ажлын жагсаалтад өөрчлөлт оруулах болон дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын задаргааны санал боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн А/44 дүгээр тогтоолоор батлуулан, дүүргийн Засаг даргын А/118, А/199 захирамжаар хөрөнгө оруулалтын ажлын өөрчлөлт, задаргааг батлан худлдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан. Хэрэгжиж дууссан 2197.4 сая төгрөгийн төсөв бүхий 44 хэрэгжиж дууссан, 629.1 сая төгрөгийн төсөв бүхий 11 ажил дуусах шатанд, 385.8 сая төгрөгийн төсөв бүхий 10 ажил гэрээ байгуулсан, 754.2 сая төгрөгийн төсөв бүхий 15 ажлын гүйцэтгэгч тодрхой шалтгааны улмаас шалгараагүй байна. Мөн тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын ажлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг тухайд нь шинчлэн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудсанд тавьж олон нийтэд нээлттэй мэдээлж ажилласан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулгыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж 6,400.0 сая төгрөгийн өртөгтэй 156 ажлын нэгдсэн жагсаалт боловсруулан нийслэлийн ЗДТГ, ЕТГ-т тус тус хүргүүлэн зөвшилцсөн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдын 32-р хуралдаанаар дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд 3.2 тэр бум төгрөг хувиарласны дагуу 2016 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт боловсруулан дүүргийн ИТХ-д өргөн барих бэлтгэл</p>	
--	--	--	--



			ханган ажиллаж байна. 2014-2015 онд нийслэл, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 саяас доош өртөгтэй хөрөнгө оруулалын ажилд иргэдийн оролцоог хангах зорилгоор 225 иргэнд олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, зааврыг танилцуулан давхардсан тоогоор 167 иргэний бүлгийг бүртгэн дүүргийн цахим хуудсанд байршуулж, 540.0 сая төгрөгийн 32 ажлыг иргэний бүлгээр гүйцэтгүүлсэн байна. Дээрх ажлын хүрээнд 185 иргэнийг түр ажлын байраар хангасан.	
18.	1.2.6. Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн болон газрын гэсэн ангиллаар явуулж, нийслэлийн өмчийн харилцааны газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулна.	СТСХ, ӨГХА	<p>2013 оны гүйцэтгэлээр :</p> <p>Эд хөрөнгийн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах тооллогын комиссыг дүүргийн Засаг даргын 2013 оны 181 тоот захирамжаар томилсон. Захирамжаар нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогыг хороод, СӨХ зэрэг газруудад зохион байгуулж 2013 оны 06 дугаар сарын 01-ний дотор дуусган нэгтгэлийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлсэн. Уг тооллогоор нийтдээ 20.9 тэрбум төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгө тоологдсон.</p> <p>2014 онд :</p> <p>2013 онд хийгдсэн тооллогоор 24-р хорооны олон улсын тусламжаар баригдаад 3 жил болсон халуун усны барилгыг бүртгэгдээгүй байсныг илрүүлж актаар хүлээн авсан байна. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар өмчийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой 5 журмын төслийг өргөн барьж батлуулсан байна.</p> <p>2015 онд:</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/42 дугаар тушаалаар Тамгын газрын 39.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хагас жилийн үзлэг тооллогоор тоолж, 124.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд шинээр авсан. Тамгын газрын даргын 2015 оны 11 дүгээр сарын 19-ний А/65 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, 1 сарын хугацаатай эд хөрөнгийн үзлэг тооллогын ажлыг эхлүүлээд байна. 2015 оны дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас 3-р улирлын байдлаар 383.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 4.9 сая төгрөгийн хангамжийн материалыг бүртгэлжүүлээд байна.</p>	75.0

**Хоёр. Ажлын байрыг нэмэгдүүлэн, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.**

**2.1. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ядуурлыг бууруулах талаар**

19.	2.1.1. Хороодын хөдөлмөрийн цахим биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн байнгын, түр, цагийн ажлын байраар хангах, зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.	НХХ, ХХ	Хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ мэдээллийг өгөх цахим машиныг 31 газарт байрлуулсан. Үүнд: Засаг даргын Тамгын газрын байр, нэг цэгийн үйлчилгээ, татварын хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсийн байр, 27 хорооны цогцолборт байрлуулан ажиллуулж байна. 2013-2015 онд цахим машинаас 13274 иргэн мэдээлэл авч үйлчлүүлсэн. Цахим машины хэвийн үйл ажиллагааг ханган хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж байна. Тус машины үйл ажиллагааг тогтмолжуулахын тулд хорооны ажилтанд зааварчилгаа өгч, байнгын асаалттай байлган ажиллуулах зааврыг машин тус бүрт байрлуулсан. Нийтийг хамарсан ажлын байранд 5287 иргэн, ногоон ажлын байранд 3683 иргэн, нийт 8970 иргэн хамрагдлаа. 2013-2015 онд хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны мэдээлэл, төрөл бүрийн мэргэжил эзэмшүүлэх сургалт, төсөл хөтөлбөрийн талаархи зөвлөгөө мэдээллийг 10018 иргэнд үзүүлсэн. Тайлант хугацаанд 18351 иргэн ажил хайж бүртгүүлснээс 10611 иргэнийг ажилд зуучилсан. Мэргэжлийн болон давтан сурах сургалтад 1383 хүнийг суралцуулсан.	75.0
20.	2.1.2. Шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэгцээний дарааллаар гарган ажил, мэргэжилгүй иргэдийг мэргэжил олгох болон мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулан тэдгээрийн 60-аас доошгүй хувийг байнгын ажлын байраар хангана.	ХХ	Иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын хэрэгцээнд тулгуурлан шаардлагатай байгаа ажил мэргэжлийн жагсаалт, судалгааг гаргасан. Мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллагад 1162 иргэнийг суралцуулав. Үүнээс гурвалсан гэрээгээр 536 иргэн, дөрвөлсөн гэрээгээр 465 иргэн суралцлаа. 2013-2015 онд аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс санаачлан ирүүлсэн төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Хөдөлмөрийн хэлтсийн даргын 2015 оны А/16, А/24 дүгээр тушаалуудаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх төслийн үндэслэлийг шалгах, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийг тус тус байгуулж, иргэдээс ирүүлсэн 310 төслөөс 79 төслийг шалгаруулан, 78.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулж, 92 ажлын байр шинээр бий болсон. Хөтөлбөрийн хүрээнд иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан ажлын байр бий болгоход зориулж аж ахуйн болон бизнес хөгжүүлэх сургалт, жижиг зээлийн төсөл боловсруулах сургалтуудыг явуулсан. Сургалтанд нийт 285 иргэн хамрагдан суралцаж төгссөн. 2013-2015 онд 4674 иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдсан.	75.0

21.	2.1.3. Дүүргийн нутаг дэвсгэрт ажлын байр шинээр бий болгох асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	НХХ, ХХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд аж ахуй эрхлэх хүсэлтэй 203 бүлгийн шаардлага хангасан 234 төсөлд 274.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж. 292 байнгын болон түр ажлын байр бий болсон. Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 295 төслийг сонгон шалгаруулж 389.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 354 байнгын ажлын байр шинээр бий боллоо. БНСУ-ын хөрөнгө оруулалттай Самдун интернейшнел төрийн бус байгууллагатай хамтран Барилгын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2014-2015 онд 6 удаа элсэлт авч, 361 иргэнийг барилгын засал чимэглэлчин, гагнуурчны сургалтад хамруулж мэргэжил эзэмшүүлснээс 120 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байна. Дүүргийн хэмжээнд 2013-2015 онд 8160 байнгын болон түр ажлын байр бүртгэгдсэн.	67.5
22.	2.1.4. Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.	НХХ, НХҮХ,	Ахмад настан ба 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд 580 иргэнийг бүртгэж, бүлгийн зохион байгуулалтанд оруулан, төмс, хүнсний ногоо тариалах сургалтанд хамрууллаа. Бүлэг тус бүрт чиглэсэн уулзалтыг зохион байгуулсан. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүлгийн 50 төслийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, 150 ахмад мэргэжилтэн иргэдэд зөвлөх үйлчилгээг үзүүллээ. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний сургалт, зөвлөгөөнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 1428 иргэнийг хамрууллаа. 2317 ажилгүй иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласнаас 1458 иргэнийг нийтийг хамарсан ажилд, 859 иргэнийг ногоон ажлын байраар хангалаа. Дээрхи иргэдийн 1359 нь өрх толгойлсон эмэгтэй байна. “Эзэнтэй Монгол” хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн бүлгүүдээс нийт 79 төсөл ирүүлснээс хамтран ажиллах гэрээ байгуулсан 71 төсөл байна. Шаардлага хангасан төслүүдийг ангилж үзвэл: 22 нь ногоон ажлын байр нэмэгдүүлэх, 47 нь нийтийг хамарсан ажил зохион байгуулах, 2 нь дэд бүтэц тохижилтын чиглэлийн төсөл байна. “Ахмад мэргэжилтнүүдийн үндэсний сүлжээ, бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, тэднийг зөвлөгөө өгөх, гэрээгээр, түр хугацаагаар ажиллуулах хөтөлбөр”-ийн хүрээнд ажил хийх хүсэл сонирхолтой, чадвартай ахмад настнуудын судалгааг гаргалаа. Судалгаанд 401 ахмад хамрагдаж, мэдээллийн санд бүртгэгдсэн. Бүртгэгдсэн ахмадуудын мэдээллийг нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржийн бүртгэлд оруулсан.	67.5

23.	2.1.5. Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуурлыг бууруулах зорилттой уялдуулж нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн ажилтнуудын ажлын арга барилыг шинэчлэж, нийгмийн халамж шаардлагатай өрх иргэдэд хүрч үйлчилнэ.	НХҮХ	Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 960 өрхийг сонгон авч тэдний амьжиргааг дээшлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Тухайн сонгогдсон 960 өрхөд чиглэсэн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай 10 төрлийн судалгааг гаргалаа. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын явцад нийт өрхүүдэд төрөл бүрийн сургалтыг явуулсан. Үүнд: Эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 173 өрхөд сургалт явуулан эрүүл ахуйн бараа материалын тусламж үзүүлж, 85 өрхийг ариун цэврийн шаардлагад нийцсэн бие засах газар, угаалтуураар хангасан. 45 өрхөд жилийн хэрэгцээний нүүрс, 10 өрхөд олон улсын байгууллагын дэмжлэгээр гэр олголоо. Хөтөлбөрийн хүрээнд 2013-2015 онд 20 ажил зохион байгуулж, 225 өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хөтөлбөрт хамруулсан. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан 1 дүгээр түвшний 960 өрхийн 5876 иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж байна. Дэлхийн зөн олон улсын байгууллагын Толгойт болон Баянхошуу орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй хамтран эдийн засгийн төсөл хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж өрхийн үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэн 9 иргэнд олон улсын байгууллагаас 8.0 сая төгрөгийн зээл олгосон. “Өрхийн үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хороодод хадгаламж зээлийн хоршоод байгуулагдаж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 266 иргэний төслийг дэмжиж, 850.0 сая төгрөгийн зээл олгоод байна.	67.5
24.	2.1.6. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлах, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар ажил зохион байгуулж, тэтгэврийн даатгалыг нөхөн авах иргэдэд мэдээлэл өгч хамруулна.	НДХ	Аж ахуй нэгж байгууллагуудад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх сургалтыг тогтмол явуулж, их дээд сургууль, коллежийн 9437 оюутныг эрүүл мэндийн даатгалд хамруулан, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалыг төр хариуцдаг иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тулд 282217 иргэний шимтгэл ногдуулалтыг хийж 952,1 сая төгрөгийн санхүүжилтийг нийгмийн даатгалын санд бүрэн төвлөрүүллээ. 2013-2015 онд дүүргийн хэмжээнд 17243 иргэн сайн дурын даатгалд хамрагдаж нийгмийн даатгалын санд нийт 7,1 тэр бум төгрөг хуримтлагдаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох ажлын хүрээнд хууль сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж, 547 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 3600 иргэнийг нөхөн даатгалд хамрууллаа. 57156 иргэдээс материал хүлээн авч, Нийгмийн даатгалын	75.0

			ерөнхий газраас 36971 иргэдийн ажилласан жил нөхөн тооцох батламж ирснээс 34701 иргэнд батламжийн хуудас олгон, нийгмийн даатгалын санд 427,7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.	
2.2. Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр				
25.	2.2.1. Эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгож, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж материаллаг баазыг нэмэгдүүлнэ.	НХХ, ЭМН	2013-2015 онд эрүүл мэндийн байгууллагуудад 558.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдлээ. АХБ-ны санхүүжилтээр 22–р хорооны “Одонт Манал” Өрхийн эрүүл мэндийн төвд 13 төрлийн үзүүлэлт үзэх, 23-р хорооны “Гурван жаргал хайрхан” Өрхийн эрүүл мэндийн төвд 6 төрлийн үзүүлэлт үзэх лабораторийн тоног төхөөрөмжийг тус тус олгож, шинжилгээ авах ажлыг анхан шатны нэгжид хийж байна. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр Нэгдсэн эмнэлгийг 52.0 сая төгрөгийн рентген аппарат, “Дезерет” олон улсын байгууллагаас 14.8 сая төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, 23.0 сая төгрөгийн цусны анализатор, нийт 89.8 төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжөөр хангав. Мөн НҮБ-ын ЮНЕСКО, Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр Нэгдсэн эмнэлгийн сэхээн амьдруулах яаралтай тусламжийн тасагт телемедицинийг байрлуулж Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрчимт эмчилгээний тасагтай шууд холбогдон ажиллаж байна. Засаг даргын нөөц хөрөнгөөс дүүргийн Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай 4D ЭХО аппарат, сэхээн амьдруулах амьсгалын аппарат авахад шаардагдах 12.9 сая төгрөгийг шийдвэрлэлээ. 2015 онд өрхийн эрүүл мэндийн төвд шээсний шинжилгээний анализатор аппаратыг олгож шинжилгээг хийж эхлээд байна.	75.0
26.	2.2.2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	НХХ, ЭМН	2013-2015 онд халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн 58581 хүн буюу 78.3%-ийг хамруулан, цусны даралт ихсэх, чихрийн шижин, хорт хавдар зэрэг өвчнүүдийг илрүүлэн эмчилсэн. 30-аас дээш насны 9146 эмэгтэйчүүдийг умайн хүзүүний хавдар, хөхний хавдрын шинжилгээнд хамруулан ажиллаа. Олон улсын байгууллагын болон дотоодын эмнэлгүүдийн нарийн мэргэжлийн эмч нарын үнэ төлбөргүй үзлэгт 2895 хүнийг хамруулан, үзлэг эмчилгээг хийлгэлээ. Эрүүл мэндийн төвд “Хоол шим тэжээлийн кабинет” шинээр байгууллаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр жирэмсэн, хөхүүл эхчүүдийн заавал мөрдөх 5/10 зарчмыг таниулах сургалтад 8 хорооны 580 ээжүүд, нөхөн сэргээх хоолны хөтөлбөрт 105 хүүхдийг тус тус хамруулж, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл тамхи, архианаас гаргах, эрүүл хооллолтын тухай “Видео” олон нийтийн хөтөлбөр боловсруулаад байна. Орчны эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг хянах, урьдчилан сэргийлэх стратегийн	75.0

			хүрээнд дүүргийн 10 хороонд “Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх нь” сургалт зохион байгуулж дүүргийн нэгдсэн төлөвлөгөөг гаргалаа.	
27.	2.2.3. Цахим бүртгэлийг хэрэгжүүлэн, хүн амд чирэгдэлгүй, товлот үйлчилгээг нэвтрүүлнэ.	ЭМН	ЭМТ, салбар амбулаториуд товлот үйлчилгээ болон хүлээгдлийг багасгах зорилгоор 49 кабинетийн үзлэгийг цахимаар бүртгэн давхардсан тоогоор 500.000 хүнд үйлчлээд байна. Мөн эмч нарын үзлэг, шинжилгээний бүртгэлийг цахим санд шилжүүллээ. Дүүргийн Эрүүл мэндийн төв нэгдсэн сервертэй болоод байна. Өрхийн эрүүл мэндийн төвөөс ЭМТ болон салбар амбулаториуд руу цаг авах тогтолцоог хэрэгжүүлж 17.964 хүнд үзлэгийн дугаар тараан үйлчлүүллээ. Эрүүл мэндийн төв, салбар амбулаториуд товлот үйлчилгээ болон хүлээгдлийг багасгах зорилгоор 49 кабинетын үзлэгийг цахимаар бүртгэн, үзлэг, шинжилгээний бүртгэлийг цахим санд шилжүүлэв. Эрүүл мэндийн төв болон салбар амбулаториудад цаг авах тогтолцоог хэрэгжүүлж өрхийн эрүүл мэндийн төвөөс шинжилгээний дугаар шууд тараах, хариуг цахимаар харах боломжтой болсон.	75.0
28.	2.2.4. Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	ЭМН	Эрүүл мэндийн байгууллагын 2215 /давхардсан тоогоор/ эмч, сувилагч, ажилтнуудыг ажлын байранд мэргэшүүлэх, чадваржуулах, ур чадварыг нэмэгдүүлэх 71 удаагийн сургалтанд хамрууллаа. Үүнд: ОХУ-ын Петербург хотын Хүүхдийн халдварт өвчин судлалын эрдэм шинжилгээний институтэд “Хүүхдийг халдварт өвчний үеийн эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах нь” сургалтад нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, -Москва хотод зохион байгуулагдсан “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, сэхээн амьдруулах” сургалтад 1 эмч, -“БАГИЙН АМЖИЛТ–МИНИЙ АЖЛААС “ сэдэвт удирдах ажилтны сургалтад Эрүүл мэндийн төвийн 25 удирдах ажилтан, -БНСУ-ын Чейл, Янжи, Гэгээн Мария, Чунь-Ань Их сургуулийн эмнэлэгүүдэд Эрүүл мэндийн төвийн 50 эмч, -Японы Токио хотын эмнэлэгт Эрүүл мэндийн төвийн 1 сувилагч, -Ургийн хөгжлийн гажигийн зарим биомаркер ба хэт авиан шинжилгээгээр эрт үед оношлох сургалтад эмэгтэйчүүдийн 4 эмч, ЭХО-ны 1 эмч, -“Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ” сургалтад Өрхийн эрүүл мэндийн төвийн 50 эмч, сувилагч, -Эрчүүдийн эрүүл мэнд ба сэтгэлзүйн тусламж үйлчилгээ сургалтад 60 эмч, -Эмнэлгийн яаралтай тусламжийн сургалтанд 60 эмч, Оновчтой сувилгаа сургалтанд 40 сувилагч тус тус хамрагдаад байна.	75.0

			Мэргэжил дээшлүүлэх /резедэнтийн/ сургалтанд төрийн сангаар 5, байгууллагын зардлаар 4, нийт 9 эмчийг сургаж байна.	
29.	2.2.5. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийн хөгжил-4” төслийн хүрээнд дүүргийн жишиг эмнэлэг байгуулна.	НХХ, НЭ	Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Жишиг эмнэлэг” барих ажил нь нийт 37,0 сая долларын өртөгтэй бөгөөд барилгад 22,0 сая, тоног төхөөрөмж, боловсон хүчний асуудалд 15,0 сая долларыг зарцуулахаар төлөвлөгдсөн байна. “Жишиг эмнэлэг”-ийн барилгын ажлын зураг, архитектурын даалгаврыг Галландын “Симэд” компани гүйцэтгэж, Солонгос улсын “Жүнгли” компани зургийг хийж ЭМСЯ-нд хүлээлгэн өглөө. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 113 дугаар тогтоолоор барилгын хөрөнгийг бүртгэлээс хасаж, нийслэлийн Засаг даргын А/786 дугаар захирамж, нийслэлийн Өмч газрын харилцааны газрын даргын А/503 дугаар тушаалаар газрын асуудлыг тус тус шийдвэрлэж, 2016 оны 4-р сараас барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.	75.0
30.	2.2.6. Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэн бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	БТСХ	Дүүргийн хүн амын биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг сайжруулах зорилгоор 700 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлыг “Боорчи” ХХК гүйцэтгэж байна. Одоогоор: <ul style="list-style-type: none"> <li>- Барилга угсралтын ажил - 98%</li> <li>- Дотор заслын ажил - 80%</li> <li>- Гадна инженерийн шугам сүлжээний ажил - 70%</li> <li>  Гадна цэвэр ус – 100%</li> <li>- Гадна бохир ус – 100%</li> <li>- Уурын зуух – 60%</li> <li>- ТП цахилгаан – 60%-тай явагдаж байгаа болно.</li> </ul> Спорт цогцолборын барилгын нэмэгдэл 1.080 сая /Нэг тэрбум наян сая/ төгрөгийн санхүүжилтыг 2015 оны улсын төсөвт суулгуулснаас 319.0 сая төгрөгийн хөрөнгөөр Боорчи ХХК том заалны ханын цонх, сантехникийн угсралт, уурын зуух, цахилгааны под станцыг барьж дуусгаад байна. Спорт цогцолборыг 2015 оны 12-р сарын 30-нд ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 2013-2015 онд биеийн тамир, спортын 105 арга хэмжээг зохион байгуулж, 1563 байгууллагын 112028 хүнийг хамруулан ажиллалаа. Дүүргийн Оюутны спортын “Универсиад-III наадам”-ыг спортын 5 төрлөөр, “Сурагчдын спорт наадам”-ыг спортын 21 төрлөөр зохион байгуулж, 459 байгууллагын 13680 оюутан сурагч, бүх нийтийн спорт өдөрлөгийг 69 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 2024 байгууллагын 132320 иргэн хамрагдлаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд аэробик, бильярд, суугаа волейбол, үндэсний сур, уралдааны дугуйн	75.0

			нээлттэй тэмцээн зохион байгуулж, 54 байгууллагын 355 тамирчинг хамрууллаа. 2013-2015 онд биеийн тамир, спортын арга хэмжээнд 109.8 сая төгрөгийг зарцуулсан.	
2.3. Боловсролын талаар				
31.	2.3.1. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлэн хичээллэх ээлжийн тоог бууруулж, анги дүүргэлтийн стандартыг мөрдүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	НХХ, БХ	Тахилтын ам, Баянголын аманд ерөнхий боловсролын 640 хүүхдийн суудалтай 122, 123-р сургуулиуд 2013 онд шинээр байгуулагдсанаар 2014-2015 оны хичээлийн жилд 1671 хүүхэд суралцаж байна. 2015 оны байдлаар 124-р сургуулийн барилгын ажлын явц 95.0 хувьтай, 1 давхарын будаг, эмульс, плитаны ажлууд, спорт, урлаг заалны тааз, дотор заслын ажлууд үлдээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх нийт 3.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий 104-р сургуулийн 640 хүүхдийн барилгын ажил 2015 онд төлөвлөсөн ажлыг 100%, нийт ажлын 40.0 хувийг гүйцэтгээд байна. 25-р хороонд бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын үндсэн барилгын ажил дууссан боловч уурын зуухны барилгын 500.0 сая төгрөгийн санхүүжилт хойшлогдосноос сургууль бүрэн ашиглалтад ороогүй. 500.0 сая төгрөгийг төсөвт тусгуулахаар холбогдох байгууллагад уламжилсан.	67.5
32.	2.3.2. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах асуудлыг шийдвэрлэнэ.	НХХ, БХ	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2014-2015 оны хичээлийн жилд 68,4 хувьтай байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд 69.9 хувьд хүрч өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 1.5 пунктээр ахисан байна. Дэлхийн банкны боловсролыг дэмжих олон улсын түншлэлийн төслийн хүрээнд 55-р цэцэрлэгийн өргөтгөл, тус бүр 100 хүүхдийн ортой 195, 196-р цэцэрлэгүүд ашиглалтад орсноор 340 хүүхдийн орны тоо нэмэгдсэн. 2015 онд 4, 7, 20-р хороодод цэцэрлэг шинээр, 91, 117-р цэцэрлэгийн өргөтгөлүүд ашиглалтад орж, 640 ороор нэмэгдсэн. 2, 11, 24, 25-р хороодод бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор баригдаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр 26-р цэцэрлэгийн хуучин барилгыг буулгаж шинэ барилгыг 2015 оны 11-р сард улсын комисс хүлээн авлаа. 2013 онд төрийн бус өмчийн 15 цэцэрлэг, 2014 онд 6 цэцэрлэг шинээр байгуулагдсанаар нийт 44 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. 2015 онд сургууль цэцэрлэггүй хороод, өргөтгөл хийх шаардлагатай сургууль, цэцэрлэгүүдийн судалгааг гаргаж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэлийн Боловсролын газар болон бусад холбогдох газруудад хүргүүлсэн.	67.5
33.	2.3.3. Сургууль, цэцэрлэгт эрүүл аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчинг бүрдүүлнэ.	НХХ, БХ	2013-2015 оны хичээлийн жилд нийслэл, дүүрэг, орон нутгийн төсөв болон гадаадын төсөл хөтөлбөрөөс нийт 2.570.9 сая төгрөгийн санхүүжилтээр 9 сургууль, 17 цэцэрлэгт эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх ажил хийгдлээ.	75.0



			<p>Үүнд: Улс, нийслэлийн төсвөөр - Ирээдүй цогцолборын 1, 2-р ахлах, 62, 65, 67, 76, 106-р сургууль, 78, 79, 104, 106, 118, 163-р цэцэрлэгүүдэд нийт 2.382.4 сая төгрөг, -Олон улсын төсөл хөтөлбөрөөс: Ирээдүй цогцолбор 1-р дунд сургууль, 79, 80, 81, 91, 104, 111, 118, 127, 148, 158, 163-р цэцэрлэгүүдэд нийт 188.5 сая төгрөгийн дотоод засварын ажлууд хийгдлээ. Эрүүл аюулгүй сургалтын гадна орчин бий болгох ажлын хүрээнд төрийн өмчийн 16 сургуульд 90 гэрэлтүүлэг, 288 хяналтын камер, төрийн өмчийн 37 цэцэрлэгт 114 гэрэлтүүлэг, 71 хяналтын камер тус тус суурилуулсан. 67, 121, 122-р сургуулиуд хүүхэд зөөх автобустай боллоо. Мөн сургуулийн сурагчдын цүнхийг цацруулагчтай болгож, сургууль орчимд "School police" аяны хүрээнд эцэг эхчүүд хуваарийн дагуу тогтмол ажиллаж байгаа нь аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж байна. 2015-2016 оны хичээлийн жилд нийслэлийн Боловсролын газраас "School police" ажиллах журам гарган нийтэд сурталчлах, даган мөрдүүлэх ажлыг хийж эхлүүлэн, сар бүр хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Энэ хичээлийн жилийн 2-р улирлын байдлаар 7200 эцэг эхчүүдээр эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгүүлээд байна. 2014-2015 оны хичээлийн жилд нийслэлийн ЗДТГ-тай хамтарсан "Эрүүл аюулгүй байдлын индексийн хариу арга хэмжээ авах аргачлал" нэгдсэн сургалтанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар хамрагдсан. Сургууль, цэцэрлэгийн удирдлагуудын үр дүнгийн гэрээнд эрүүл аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тусгаж, биелэлтийг тооцох ажлыг зохион байгуулж байна.</p>	
34.	2.3.4. Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэдэх хоолны газрыг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлж, баталгаатай хоол хүнсээр үйлчлэх бүх нөхцлийг бүрдүүлж үдийн цай хөтөлбөрийг чанаржуулна.	НХХ, БХ	<p>2013-2015 оны хичээлийн жилд "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааг чанаржуулах ажлын хүрээнд дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн цайны газар, хүнсний аюулгүй байдал, цэцэрлэгийн гал тогооны эрүүл ахуйн байдлыг сайжруулах зорилгоор 5 удаагийн хамтарсан шалгалтыг зохион байгуулж, 450 /давхардсан тоогоор/ сургууль, цэцэрлэгийг хамруулсан. Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд эцэг, эхийн хяналтыг тогтмолжуулж, эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сургуулийн захирлын тушаалаар батлагдсан "Орон тооны бус хяналтын зөвлөл" хяналт тавьж хэвшүүллээ. Нийслэлийн Боловсролын газрын даргын 2014 оны 11-р сарын 17-ны өдрийн А/103 дугаар тушаалаар Үдийн цай хөтөлбөрт хяналт шинжилгээ хийх зорилгоор төрийн өмчийн 22, төрийн бус өмчийн 4 сургуулийн цайны газарт 31 төрлийн асуулгын дагуу</p>	75.0

			мониторингийн шалгалт хийсэн. 2015 оны 9-р сард “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний улсын 2-р зөвлөгөөн” зохион байгуулагдсан бөгөөд зөвлөгөөнд дүүргийн сургууль, цэцэрлэгийн 10 тогооч хамрагдаж, ур чадвараа дээшлүүлэн, харилцан туршлага судаллаа. 2015-2016 оны хичээлийн жилд нийслэлийн Захирагчийн ажлын алба, Боловсролын газар, Эрүүл мэндийн газартай хамтран баг бүрдүүлж сургуулийн цайны газар, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.	
35.	2.3.5. ЕБС-уудыг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлж, бага, дунд боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.	НХХ, БХ	“Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх тухай” албан даалгавар, “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийн хүрээнд бага дунд боловсролын чанарын шинэчлэл, хүүхдийн хөгжил, багшлахуйн арга зүйн хөгжлийг дэмжин цөм хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх ажлыг 3 үе шаттайгаар үндэсний лаборатори Ирээдүй цогцолбор, 12-р сургуулийг түшиглэн зохион байгуулан ажиллаж байна. Ирээдүй цогцолбор, 12-р сургуулиуд бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг нийслэлийн бүх сургуульд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Бага, дунд боловсролын шинэчлэлийн хэрэгжилтийг Боловсрол, шинжлэх ухааны яам, нийслэлийн Боловсролын газарт 5-р сард тайлагналаа. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг БНХАУ-ын Манжуур, Хайлаар хотуудад туршлага судлуулах аяллыг зохион байгуулсан. Нийслэлийн Боловсролын газраас 4, 6-р сард зохион байгуулсан шинэчилсэн хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалтанд 58 багш, сургалтын менежерийг хамруулав. “Багш солилцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр багш нар харилцан бие биенээсээ туршлага судлалж, хамтран ажиллаж хэвшээд байна. 2015-2016 оны хичээлийн жилд 157 багш хамрагдсан. Сургууль бүр судлагдахууны 15-20 иж бүрэн хичээлийн сантай боллоо. Ирээдүй цогцолбор, 12-р сургуулийн багш, сургалтын менежер, нийгмийн ажилтнуудаас бүрдсэн баг Японы боловсролын байгууллагын үйл ажиллагаа, тухайлбал Токио хотын сургуулийн сургалтын үйл ажиллагаа, ажлын арга барилтай танилцаж туршлага судалсан.	75.0
36.	2.3.6. Ерөнхий боловсролын сургуулиудыг цахимжуулах, эцэг эх, багш, сурагчдад зориулсан мэдээллийн төвүүд, суралцагчдын амьдрах ухаан, харилцааны ур чадвар, сэтгэн	НХХ, БХ	Ерөнхий боловсролын 9, 12, 42, 62, 65, 67, 76, 105, 106, 107, Ирээдүй цогцолборын 2, 3-р бага, 2-р дунд, 2 дугаар ахлах сургуулиуд суурин интернетэд холбогдсоноор нийт сургуулиудын 70 хувь нь суурин интернет, 30 хувь нь зөөврийн интернэтийн сүлжээнд холбогдсон. 2014-2015 оны хичээлийн жилд 22 сургуульд 1219 ширхэг компьютерийг сургалтад ашиглаж байна. Нийслэлийн Боловсролын газраас 28,0 сая төгрөгийн	75.0

	бодох, өөрийгөө илэрхийлэх чадварыг бүрдүүлэх “book safe”-г байгуулна.		<p>өртөгтэй 24 компьютерийг 67-р сургууль, Боловсролын хэлтэст шинээр олгов. 2014-2015 оны хичээлийн жилд боловсролын байгууллагын суралцагч, багш боловсон хүчний статистик дэлгэрэнгүй мэдээллийн санг цахимаар бүрдүүллээ. Сургууль, цэцэрлэгүүд байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлах, таниулах, багш эцэг эхчүүд, суралцагчдад нээлттэй байх зорилгоор “facebook”, “blog”, Shd.edub.edu.mn Боловсролын хэлтсийн вэб хуудсыг нээн ажиллуулж, мэдээллийг нийтэд ил тод, түргэн шуурхай ажиллуулж байна. “Ирээдүй цогцолбор” I ахлах сургууль дээр Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, “ROTORU” агентлагтай хамтран 19.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн “Номын гэр” танхимыг байгуулан үйл ажиллагаа нь тогтмолжсон. 2015-2016 оны хичээлийн “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд “Багш бүрийг компьютержүүлэх” аян явагдаж багш нарт 1616, сурагчдад зориулсан 784 компьютер хуваарилагдаад байна.</p>	
37.	2.3.7. Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.	НХХ, БХ	<p>2013-2014 оны хичээлийн жилд дүүргийн боловсролын байгууллагуудын төлөөлөл 1000 багш нарын “Боловсролын шинэчлэлд хамтдаа” сэдэвт уулзалтыг төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Төгсөлтийн баяр сарын аяныг ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн сурагчдын дунд зохион байгуулж, бүтээлч ажлаар “Гэрэлт–Ирээдүй” дунд сургууль шалгарч, Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. 2014-2015 оны хичээлийн жилд дүүргийн боловсролын байгууллагуудын дунд “Боловсролын шинэчлэл” уулзалт зөвлөгөөнийг Найрамдал зусланд зохион байгуулж, төрийн бус өмчийн 8 сургууль, 38 цэцэрлэгийн нийт 46 удирдах ажилтан оролцсон. Төрийн ба төрийн бус өмчийн цэцэрлэгийн багш харилцан туршлагаа солилцож, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн үзэл баримтлалын хэрэгжилт, багшийн арга туршлагаас суралцах, сургалт арга зүй, бичиг баримт боловсруулалтын талаар туршлага судлан хамтран хөгжих нөхцлийг бүрдүүллээ. “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого” сэдэвт сургалтыг НБГ-ын Хяналт үнэлгээ шинжилгээний хэлтэстэй хамтран төрийн бус өмчийн боловсролын байгууллагын удирдлагуудад зохион байгуулав. Дүүргийн хэмжээнд 2015-2016 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн 7 цэцэрлэг шинээр байгуулагдаж, нийт 51 цэцэрлэг, 8 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Хувийн хэвшлийн СӨБ-ын байгууллагын холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж дүүргийн эмзэг өрхийн хүүхдүүдийг хоолны зардал 36000 төгрөгийг хариуцан 18</p>	75.0

			цэцэрлэгт 415 хүүхдийг хүмүүжүүлж байна. Төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн холбоотой хамтарч багш нарыг чадавхжуулах зорилгоор 6 удаагийн шинэчилсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор 447 багш удирдлагууд хамрагдсан байна. Төрийн бус өмчийн 6 сургуулийн 12 багшийг лаборатори сургуулийн багш нарын хичээлд суулган хэлэлцүүлэгт оруулсан.																																									
38.	2.3.8. Гэгээрэл хөгжлийн төвийг бие даасан ажлын байртай болгож, Гэгээрэл хөгжлийн төвийн үйл ажиллагааг албан бус боловсролын үйлчилгээнээс иргэн бүрт хүрч үйлчлэх “Насан туршийн боловсролын төв” болгон өргөжүүлнэ.	НХХ, ГХТ	<p>Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1102 дугаар захирамжаар албан бус боловсролын “Гэгээрэл” хөгжлийн төвийг “Албан бус-Насан туршийн боловсролын төв” болгон өөрчилсөнтэй холбогдуулан төвийн дүрэм, бүтэц, орон тоо, төвийн захирлын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулсан.</p> <p>2014 онд Албан бус-Насан туршийн боловсролын төвийн барилга бариулах хүсэлтийг нийслэлийн нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтын саналд тусгуулахаар дүүргийн Засаг даргын 1/1020 албан тоотой хүргүүлсэн.</p> <p>2015 онд төвийн байр бариулах саналыг Засаг даргын 2015 оны 01/521 дугаартай албан бичгээр нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн.</p>	75.0																																								
			<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Сургалтын нэр</th> <th>2012-2013 оны хичээлийн жил</th> <th>2013-2014 оны хичээлийн жил</th> <th>2014-2015 оны хичээлийн жил</th> <th>2015-2016 оны хичээлийн жил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Дүйцсэн хөтөлбөрийн-Боловсрол нөхөн олгох сургалт</td> <td>158</td> <td>145</td> <td>162</td> <td></td> </tr> <tr> <td rowspan="3">2</td> <td rowspan="3">Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт</td> <td>Бизнестэй танилц</td> <td>39</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Эсгий урлал</td> <td>62</td> <td>42</td> <td>50</td> </tr> <tr> <td>Сүлжмэл урлал</td> <td></td> <td>20</td> <td>51</td> </tr> <tr> <td rowspan="3">3</td> <td rowspan="3">Боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх</td> <td>Англи хэл</td> <td>15</td> <td></td> <td>20</td> </tr> <tr> <td>Компьютер</td> <td>43</td> <td>32</td> <td>23</td> </tr> <tr> <td>Бичиг үсэг</td> <td>58</td> <td>69</td> <td>27</td> </tr> </tbody> </table>	№	Сургалтын нэр	2012-2013 оны хичээлийн жил	2013-2014 оны хичээлийн жил	2014-2015 оны хичээлийн жил	2015-2016 оны хичээлийн жил	1	Дүйцсэн хөтөлбөрийн-Боловсрол нөхөн олгох сургалт	158	145	162		2	Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	Бизнестэй танилц	39			Эсгий урлал	62	42	50	Сүлжмэл урлал		20	51	3	Боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх	Англи хэл	15		20	Компьютер	43	32	23	Бичиг үсэг	58	69	27	
№	Сургалтын нэр	2012-2013 оны хичээлийн жил	2013-2014 оны хичээлийн жил	2014-2015 оны хичээлийн жил	2015-2016 оны хичээлийн жил																																							
1	Дүйцсэн хөтөлбөрийн-Боловсрол нөхөн олгох сургалт	158	145	162																																								
2	Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	Бизнестэй танилц	39																																									
		Эсгий урлал	62	42	50																																							
		Сүлжмэл урлал		20	51																																							
3	Боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх	Англи хэл	15		20																																							
		Компьютер	43	32	23																																							
		Бичиг үсэг	58	69	27																																							

			сургалт						
			4	Амьдрах ухаан	Экологи	2000	1340	709	52
					Эрүүл мэнд	2000	1340	546	
					Ухаалаг амьдрах	2000	2554	728	
			5	Иргэний боловсрол	-	-	-		82
			6	Гэр бүлийн боловсрол	-	-	-		72
			7	Ёс суртахуун-Төлөвшлийн боловсрол	-	-	-		99
			8	Гоо зүй-мэдрэмжийн боловсрол	-	-	-		82
2.4. Соёл, урлагийн чиглэлээр									
39.	2.4.1. Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.	НХХ	<p>2013-2015 онд Жаргалант тосгоны соёлын ордны морин хуур, уртын дуу, бүжиг, хөгжим, дуу, язгуур урлагийн дугуйланд 66 хүүхэд хамрагдаж байна. 74-р сургуулийн сурагчдын бүжгийн “Домог” хамтлагийг 12, буриад дууны “Мойлхон” хамтлагийг 2 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр, 10 хүүхдийн бүрэлдэхүүнтэй “Бөмбөрийн чуулга”, 62-р сургуульд 8 хүүхдийн бүрэлдэхүүнтэй “Морин хуурын чуулга” тус тус байгуулагдсан. 2015 онд Засаг даргын А/115 дугаар захирамжаар шилдэг тохижилттой хороо, өрх, орон сууцны байр, гэр хорооллын гудамж болзолт уралдааныг зарлаж, 2015 оны 10 дугаар сард шалгарууллаа. Үүнд:</p> <p>Шилдэг тохижилттой хороо: 25, 29, 9 дүгээр хороо,  Шилдэг тохижилттой өрх: 32, 25, 7 дугаар хорооны иргэнд  Шилдэг тохижилттой орон сууцны байр: Тохилог-21, Итгэл-1, Кремль СӨХ  Шилдэг тохижилттой гэр хорооллын гудамж: 25-р хорооны Хайрханы 9-р гудамж, 9-р хорооны Малчны 2-р гудамж тус тус шалгарлаа.</p> <p>Иргэдийн дунд соёлыг хэвшүүлэх, гоо зүйн зөв дадал эзэмшүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын даргын 2015 оны А/41 дүгээр тушаалаар “Монгол цэргийн жавхаа-2015” үдшийн цэнгүүн, Засаг даргын 2015 оны А/112 захирамжаар Иргэдийн баяр -2015 наадам, А/281 дүгээр захирамжаар Дээлтэй Монгол-2015 наадмыг тус тус зохион байгууллаа. Арга хэмжээнүүдэд нийт 4500 иргэдийг хамруулсан.</p>						75.0
40.	2.4.2. Соёл, урлагийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг чанартай	НХХ	<p>Соёл, урлагийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хүрээнд 2013-2015 онд 177 утга соёлын өв тээгч бүртгэгдсэн. Үүнд:</p>						75.0

	хэрэгжүүлнэ.		<ul style="list-style-type: none"> <li>- Уртын дуу дуулаач - 35</li> <li>- Сийлбэрчин - 8</li> <li>- Морин хуурч- 23</li> <li>Хөгжимчин - 18</li> <li>- Гар урлал - 14</li> <li>- Ерөөлч магтаалч - 6</li> <li>- Зураач - 8</li> <li>- Бий биелгээч- 15</li> <li>- Хайчилбар -1</li> <li>- Хөөмийчин - 6</li> <li>- Алт мөнгөний дархан -2</li> <li>- Шагай харваач- 1</li> <li>- Барималчин 1</li> <li>- Бөх цоллооч -5</li> <li>- Зохиолын дуучин- 31</li> <li>- Туульч- 3 иргэн судалгаанд хамрагдлаа.</li> </ul> <p>Улаанбаатар чуулгатай хамтран “Монгол уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэе” 3 сарын сургалтад 14 ардын авьяастанг суралцуулсан. Ардын авьяастнуудын дунд зохион байгуулсан “Хууртай мөнхрөх аялгуу” уралдаанд 22-р хорооны ардын авьяастан Жаргал, Сүхбат нар амжилттай оролцлоо. “Авьяаслаг гэр бүл” шалгаруулах улсын уралдаанд 22-р хорооны ардын авьяастан Наранбаатарын гэр бүл тусгай байрын шагнал хүртэв. “Уламжлалт бий биелгээ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Хөгсүү” чуулга, Монголын бий биелгээ өвлүүлэх холбоотой хамтран үндэсний бий биелгээ бүжгийг язгуур төрхөөр нь 17 сургуулийн 1000 гаруй сурагчдад зааж сургалаа. “Монгол хөөмий” дэд хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн Соёл урлагийн газар, Жаргалант тосгоны соёлын ордонтой хамтран “Хөөмийн уянга” хөөмийчдийн уралдааныг уламжлал болгон зохион байгуулж нийт 155 ардын авьяастан оролцсон.</p> <p>Жаргалант тосгоны соёлын ордны дугуйлангийн сурагчдын санаачилгаар хандивын тоглолт зохион байгуулан 116-р цэцэрлэгийн ардын ёс заншлын танхимыг тохижуулсан. Ардын урлагийн талаарх лекц-тоглолтыг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж, 600 сурагчийг хамруулав. 2015 оны 10-р сард 74-р сургуулийн 2-7-р ангийн 200 сурагчдын дунд ардын ёс заншлыг сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр ардын уламжлалт тоглоом наадгай, монгол</p>	
--	--------------	--	--	--

			зан үйлийг сурталчилан, АХА тэмцээн явуулсан байна.	
41.	2.4.3. Дүүргийн соёл, урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна	НХХ	Ардын урлагийн их наадмыг зохион байгуулж, соёлын биет бус өв-ардын уламжлалт урлагийн төрөл зүйл, мартагдсан ховордсон өвийг сэргээх, эх байдал, өвөрмөц байдлыг харгалзан сонгон шалгаруулалтыг зохион байгуулав. Наадамд 32 хорооны 1000 гаруй ардын авьяастан оролцож, 1-р байранд 22-р хороо, 2-р байранд 32-р хороо, 3-р байранд 13-р хороо, тусгай байранд 1-р хороо тус тус шалгарсан. Хүүхдийн урлагийн “Солонго” их наадмын 1, 2-р шатны шалгаруулалтыг зохион байгуулж, ардын хөгжмийн сонгодог урлаг, ардын бүжиг бий биелгээ, морин хуурын татлага, хөөмий, ерөөл магтаал, уламжлалт сонгодог бүжиг, хамтлагийн дууны төрлөөр 22 сургуулийн 800 гаруй сурагчид оролцсон. Дүүргийн Засаг даргын А/127 дугаар захирамжаар Монголын хүүхдийн байгууллагын 90 жилийн ойг угтаж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн дунд язгуур урлаг, уран уншлагын наадмыг Хүүхэд гэр бүл хөгжлийн төвтэй хамтран зохион байгууллаа. Уралдаанд 79, 80, 84, 91, 92, 107, 117, 158, 192, 195–р цэцэрлэг, 12-р сургуулийн авьяаслаг 120 сурагчид оролцож. гоцлол дуу, хамтлаг дуу, уран уншлага 3 төрөлд өрсөлдлөө. “ВОВ” энтертаймент, нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд урлагийн наадмыг 11-р сард зохион байгуулж 10 сургуулийн 800 сурагчийг хамруулсан.	75.0
42.	2.4.4. Дүүргийн Соёлын төвийг байгуулж иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	НХХ	Дүүргийн Засаг даргын 406 дугаар захирамжаар 1-р хорооны нутаг дэвсгэр Баянголын аманд 5000 м2 соёлын ордон бариулах газрын асуудлыг шийдвэрлэсэн. Соёлын ордны зураг төсвийг гүйцэтгэх сонгон шалгаруулалт нийслэлийн Барилга, хот байгууллалтын газраас зарлагдаж “Baldans” ХХК шалгарч 850 хүний суудалтай барилгын зураг, төсвийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 2016-2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд Соёлын ордон бариулах талаар Засаг даргын орлогчийн 2015 оны 02/1194 албан тоотыг Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар хүргүүлэв.	75.0
2.5. Хүүхэд, залуучуудын талаар				
43.	2.5.1. Хүүхэд хөгжлийн төв байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.	НХХ	Засаг даргын 2013 оны 04 дүгээр захирамжаар Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн бүтэц орон тоог баталж, 13 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Тус төв 22,5 сая төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжтэй болж, үйл ажиллагаа нь жигдэрсэн. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн барилгыг 27-р хорооны нутаг дэвсгэрт барихаар оршин суугчдаас барилга барих зөвшөөрлийг гарын үсгээр баталгаажуулан авч нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар хүргүүлэн ажиллалаа.	75.0

44.	2.5.2. Гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	НХХ, ХГБХТ	<p>Өөрчлөлт төслийг 2013 онд санаачлан эхлүүлж, нийгмийн эмзэг бүлгийн, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, орон гэргүй, сургууль завсардсан хүүхэдтэй, ажил, мэргэжилгүй 8 өрхийн 30 хүнийг хамруулан PPTV-тэй хамтран уг төслийг хэрэгжүүлэн 32 удаагийн нэвтрүүлгийг бэлтгэсэн. Апу, Тесо, Миний дэлгүүр зэрэг ААНБ-ууд ивээн тэтгэн 2 иргэнд гэр олгож, 5 иргэнийг мэргэжил олгох сургалтад, сургууль завсардсан 3 хүүхдийг бүрэн дунд боловсрол эзэмшүүлж, 8 иргэнийг ажлын байртай болгосон. 2014 онд “Өөрчлөлт” төслийн хүрээнд хараа хяналтгүй хүүхдүүд, архины хамааралтай гэр бүлийг нийгэмшүүлэх зорилгоор дүүргийн архины хамааралтай иргэдэд сургалт зохион байгууллаа. Сургалтанд 451 иргэн хамрагдаж, 5-р хороонд архины хамааралтай, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх төвийг байгуулах ажлыг дэмжиж гэр олгов. Төслийн хүрээнд бичиг баримтгүй 30 гаруй иргэдийг бичиг баримтжуулж, 5 иргэнийг ажилд зуучлан 3 иргэнийг мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулсан. Архины хамааралтай гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилгоор “Аз жаргалтай гэр бүл-2” өдөрлөгийг Ерөөгдсөн гэр бүл ТББ-тай хамтран 2015 оны 03-р сард өдөр зохион байгуулж 70 иргэнийг оролцууллаа. “Үндэсний өгөх өдөр”-ийг 2013-2015 онд 3 удаа зохион байгуулж, нийт 94.0 сая төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг өгөх ажлыг зохион байгуулав. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр "Ачлалт ээж"-ийг шалгаруулж, "Хүндэт ээж" 35, "Ачлалт ээж" 20, "Дархан бэр" 12, "Шилдэг залуу ээж" 5 нийт 72 ээжийг, Зэвсэгт хүчний баярын өдрөөр "Ачлалт аав", "Хүндэт аав" номинациар 20 аавыг алдаршуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан. “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан 70 эмэгтэйг Эрүүл мэндийн төвтэй хамтран дотор, эхо оношлогоо, эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн сургалт явуулав. Мөн олон Улсын гэр бүлийн өдрөөр дүүргийн 60 гэр бүлийг “Family awards-2014” үндэсний шалгаруулалтын ёслол хүндэтгэлийн ажиллагаанд оролцууллаа. Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан эх үрсийн баярын арга хэмжээг зохион байгуулж нийт 7000 гаруй хүүхэд багачууд хамрагдсан байна. “Гэр бүл хөршийн холбоо”, “Амьдралд бэлэн” сургалт зохион байгуулах 16 сургагч багш бэлтгэж, 12 удаагийн сургалтанд 24 гэр бүл, 100 гаруй хүүхдийг хамрууллаа. 2015 онд Хүүхдийн тусламжийн утас 108-аас 220 дуудлага, гомдол хүлээн авч хороодын хамтарсан баг болон сургууль, цэцэрлэгүүдтэй хамтран шийдвэрлэлээ. Гэр бүлийн хүчирхийллийн утас-107-оос 8 гомдол хүлээн авч холбогдох гэр бүлд нь нэгтгэх, асрамж халамжийн төвд</p>	75.0
-----	---	---------------	--	------



			шилжүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 102 тусгай дугаарын утсанд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлагын дагуу 28 гэр бүлд нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлж, тухайн гэр бүлүүдэд хяналт тавин ажиллаж байна. Олон Улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан “Ээжтэйгээ авахуулсан зураг эрхэм”, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Аавтайгаа авахуулсан зураг эрхэм” фото зургийн үзэсгэлэн, хэлэлцүүлэг зохион байгуулж Ирээдүй цогцолбор сургуулийн ахлах, дунд ангийн нийт 104 бүлгийн 2508 хүүхэд хамрагдав. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2015 оны 05 сарын 30-ны өдөр хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд олон хүүхэд төрүүлж өсгөсөн дүүргийн 15 ээжид Алдарт эхийн 1,2-р одонг гардуулж, урлаг спортоор тэргүүлсэн 20 хүүхдийг алдаршуулж гарын бэлэг өгсөн. Зорилтод бүлгийн 1000 хүүхдийг үнэ төлбөргүй циркийн тоглолт үзүүлэв. Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагатай хамтран “Хамтдаа инээмсэглэе” уулзалт өдөрлөгийг зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдийг оролцуулав. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан шилдэг гэр бүлүүдийг алдаршуулж, хөгжөөнт тэмцээн, туршлага солилцох уулзалт, сургалтыг зохион байгуулж 900 гаруй иргэдийг оролцууллаа.	
45.	2.5.3. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон эмзэг бүлгийн хүүхэд, залуучуудад нийгмийн ажлын үйлчилгээг хүргэнэ.	НХХ, ХГБХТ	Хүнд нөхцөлд байгаа 348 иргэнд кейс нээн шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэн ажиллаа. Нөхцөл байдлын үнэлгээг 348 гэр бүлд хийж, 101 хүүхдийг асрамж, сувиллын газар асруулж, 24 хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэж, 223 хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны А/162 дугаар тогтоолоор гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалж, байцаан шийтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, тэдэнд нийгэм, эрх зүйн туслалцаа үзүүлэх дүүргийн “Хүүхдийн хууль зүйн хороо”-г байгууллаа. Хүүхдийн хууль зүйн хорооны гишүүдийн чадавхи бэхжүүлэх сургалтанд 14 гишүүн хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг, эхтэй уулзах уулзалт зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт хандлага, хүүхдийн хөгжил эцэг, эхийн оролцооны талаар мэдлэгийг олгож гарын авлага тараав. Хүүхэд гэр бүл хөгжлийн төв автомашинтай болсноор цаг алдалгүй газар дээр нь нөхцөл байдлыг судлаж, холбогдох арга хэмжээ авч, хөдөлгөөнт кейсийн үйлчилгээг үзүүлж байна. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай үзүүлэх зорилготой	75.0

			<p>хорооны хамтарсан багийг шинэчлэн байгуулж зөвлөмжийг хороодод хүргүүллээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хороодын хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гишүүдийг чадавхижуулах сургалтыг ХБНГУ-ын Хайнс Зайделийн сан, Япон улсын Хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулж нийт 116 хамтарсан багийн гишүүн оролцлоо. “Цэнхэр гариг” ТББ-тай хамтран эрх нь зөрчигдсөн хүүхдийн эрхийг хамгаалж, хууль зүйн үйлчилгээ үзүүлэх төслийг 6 сарын хугацаанд хэрэгжүүлэн 9 өрхийн 18 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд хамруулж, эцэг эхчүүдийн эрхийг хязгаарлах, сургалтанд хамруулах, нийгэмшүүлэх, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх ажлуудыг зохион байгууллаа. 2015 оны шинэчилсэн судалгаагаар дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэгч 44 хүүхэд бүртгэгдсэн. Хорооны нийгмийн ажилтан, дүүргийн Цагдаагийн 1.2.3-р хэлтэстэй хамтран илрүүлэлтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн эсрэг” олон улсын өдрийг угтан “ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТ ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЬЕ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛД ЗА ГЭЖ ХЭЛЬЕ” өдөрлөгийг дүүргийн хөдөлмөр эрхлэгч насанд хүрээгүй хүүхдүүд болон тэдний эцэг, эх мөн амьдарлын баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүд, эцэг, эхийг хамруулан нийт 20 хүүхэд, 40-н эцэг, эхчүүдийг хамруулан зохион байгууллаа. Хөдөлмөр эрхлэгч 24 хүүхдийн ар гэрт очиж, нөхцөл байдлын үнэлгээ судалгаа хийх ажлыг зохион байгуулж, эцэг, эх, асран хамгаалагчдад нь үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлэх талаар зөвлөгөөг өгч ажиллалаа.</p>	
46.	2.5.4. Хүүхэд, залуучуудыг аливаа эрсдэл, хорт зуршил, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	НХХ, ХГБХТ, ЦХ I, II, МХХ	<p>Ерөнхий боловсролын сургууль, Цагдаагийн 1, 2-р хэлтэстэй хамтран архи тамхины хор уршгийг таниулах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалтыг 620 сурагчид зохион байгуулсан. Интернет кафе, цахим тоглоомын газрын үйлчилгээг зохицуулах нийтлэг журмыг боловсруулан интернэт, цахим тоглоомын газрын эзэдтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн 10, 11-р ангийн хүүхдүүдийн дунд “Хар тамхи, мансуурал, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Тамхины хяналтын тухай хууль”-ийг сурталчлан “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулав. “Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж” гарын авлага, тараах материалыг сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, эмийн сангуудаар тарааж, хороо, аж ахуй нэгж байгууллагуудын мэдээллийн самбарт байршуулан</p>	75.0

			ажилласан. “Бид хорт зуршлаас татгалзаж байна” аяныг өрнүүлж, ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчид, их дээд сургуулиудын оюутнуудад сургалт зохион байгуулж, гарын авлага тараасан. “Хүүхэд буруугүй” аяны хүрээнд дүүргийн Цагдаагийн 2-р хэлтэс, 25-р хороотой хамтран 104-р сургууль дээр 9-12-р ангийн 160 хүүхдэд “Хүүхдийн эрх, үүрэг” болон “Хүүхдийн осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулав. “Хүүхдүүд хорт зуршлаас татгалзаж байна” аяны хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн анатомийн тэнхим, шүүх эмнэлгийн эмгэг судлалын тэнхимтэй хамтран хорт зуршлаас үүдэлтэй хүний бие махбодид хожим гарах өөрчлөлт, ямар үр дагавар хор уршгийг таниулах зорилготойгоор дүүргийн “Хүүхдийн холбоо”-ны сурагчдад болон дүүргийн ЕБС-ийн ахлах дунд ангийн нийт 100 сурагчдад анагаахын анатомийн музей болон шүүх эмнэлгийн эмгэг судлалыг музейг үзүүлж сургалтыг зохион явуулав. ХҮҮХЭД ШИЙТГЭХГҮЙ БАЙХ ӨДӨР”-ийг угтан “Хүүхдийн хүмүүжил, төлөвшил” сэдэвт сургалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхэд, өсвөр үеийн клиник, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллага дахь Толгойт орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран ерөнхий боловсролын 9 сургуулийн 1150 сурагчийн эцэг эх, 2845 сурагч болон сургуулийн 514 багш албан хаагчдад зохион явууллаа.	
47.	2.5.5. Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах ажлыг зохион байгуулна.	НХХ, ХГБХТ	2013-2015 онд нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх чадваржуулах сургалтыг “Хөгжлийн бэрхшээлийг ойлгох нь” “Нийгмийн ажил”, “Өрхийн сургалт үнэлгээ” “Гэр бүлийн үнэ цэнэ” “Кейс менежмент”, “Кейс илрүүлэлт хийх арга зам” сэдвээр 23 удаа зохион байгуулав. Хүүхдийн тусламжийн утас-108-ыг танилцуулах, утсанд ирсэн кейсүүдэд хариу үйлчилгээ үзүүлэх сургалтыг Хүүхдийн төлөө үндэсний газар, Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газартай хамтран дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн ажилтнууд, хороодын нийгмийн ажилтнуудад зохион байгуулав. Нийгмийн ажилтны үндэсний анхдугаар зөвлөгөөнд 10 албан хаагчийг хамруулж оролцуулсан. 29-р тусгай сургуультай хамтран хорооны нийгмийн ажилтнуудыг дохионы хэлний сургалтанд хамруулж батламж олгов.	75.0
Гурав. Иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.				
3.1. Дэд бүтцийн талаар				
48.	3.1.1. Дүүргийн нутаг дэвсгэрийн	ДБТХ	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр инженерийн гадна, дотор шугам	75.0

	<p>орон сууцны хуучин барилгуудын инженерийн шугам сүлжээг сайжруулна.</p>		<p>сүлжээг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дээр хийгдэх шаардлагатай ажлуудын саналыг ОСНАА-н орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас нэгтгэн авч ЗАА-ны Инженерийн байгууламжийн хэлтэст ЗДТГ-ын Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн даргын 3/520 дугаар албан бичгээр хүргүүлсэнээр тайлангийн хугацаанд доорхи ажлууд хийгдсэн болно. Үүнд:</p> <p>13 дугаар хорооны 11 дүгээр байрны оруулгын 50у/м 5 хос шугам. 12, 13, 14 дүгээр хорооны орон сууцны 5,11,12,13, 14 дүгээр байрны хэрэгцээний халуун усны дотор системийн ф 32-Ф100 мм 103 у/м шугамыг хэсэгчлэн, 112-р цэцэрлэгээс контор хүртэлх хэрэгцээний халуун, хүйтэн усны ф 50 мм 60 у/м гадна шугам, 19 дүгээр хорооны 21 дүгээр хорооллын орон сууцны халаалтыг сайжруулах зорилгоор Ф50-Ф150мм 731,4 у/м шугам, 15 дугаар хорооны 19,20 дугаар байрны дундах Ф80-Ф100мм 240 у/м шугам, 18-р хорооны угсармалын 7 дугаар байрнаас 5, 12 дугаар байр хүртэл гадна дулаан, ус хангамжийн шугамыг тус тус шинэчлэн сольсон. 21-р хороо Жаргалант тосгоны Захирагчийн ажлын албаны гаднах 173 у/м шугам сүлжээний шинэчлэлтийг “Бөртө” ХХК 58,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Ханын материалын бохирын шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг “Бумбод” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын шинэ төв Ханын материал орчмын орон сууцны байруудын дулааныг нэмэгдүүлэхээр 1500 метр газарт 800-ийн хос шугам татах ажил хийгдэж дууссан.</li> <li>- 1-р хорооллын Саппоро үйлчилгээний төв хүртэлх 95 метр 1-р хэлхээний өгөх, буцах шугам шинэчлэн солих ажлыг “БЦГ” ХХК хийж гүйцэтгэсэн.</li> <li>- Цэргийн хотхоны УДДТ -2-ын 1-р хэлхээний Ф200-250 мм шугамыг 1241 у/м газар бүрэн шинэчлэн сольсон.</li> <li>- 1-р хорооллын УДДТ-2 -ын харъяа 11-р байрны гадна дулааны худгаас 9-р байр хүртлэх халаалтын болон хэрэгцээний халуун, хүйтэн усны Ф100-200 мм-ийн 40 у/м магисраль шугамыг шинэчлэх ажлыг “ Уран тамир” ХХК хийж гүйцэтгэсэн.</li> <li>- Таван шарын УДДТөвөөс А худаг хүртэлх гадна траншейнд халуун усны ф125мм труба 84 у/м, хүйтэн усны труба 30 у/м хэсэгчилэн шинэчилсэн. Ус дулаан дамжуулах 6 төв болон халаалтын цогц төхөөрөмж бүхий 6 байрны засвар үйлчилгээ хийж, 21 ялтсан бойлер, 53 насос, хог шүүгч, хаалт арматуруудыг задалж цэвэрлэн, тосолгоо үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.</li> <li>- Нутаг дэвсгэрийн орон сууцны хуучин барилгуудын инженерийн шугам</li> </ul>	
--	--	--	---	--

			<p>сүлжээг сайжруулж, шинэчлэн солих их болон урсгал засварын ажлын хүрээнд “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, ОСНААУГ-ууд дараах ажлуудыг төлөвлөн гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <p>ОСНААУГ-ын харъя ХҮТ-үүд орон сууцны 182 байр, ялтсан бойлер бүхий дулааны төвлөрсөн 12 узелийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн чанар ашиглалтын түвшинг тогтооход тоног төхөөрөмж инженерийн шугам сүлжээний ашиглалт 88,3 хувь, гадна болон усан хангамжийн сүлжээний ашиглалт 86%, төвлөрсөн бойлер болон узелийн ашиглалт 90%, цахилгаан болон тоноглолын ашиглалт 84,2%, холигч насосны ашиглалт 89,3% тус тус байна. Эдгээр инженерийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн ашиглалт, гэмтэл засварыг арилгах ажлын хүрээнд УДДТ-2-ын харъяа 9-р байрны 1-3-р орцны халуун хүйтэн усны магистраль шугамыг өргөтгөсөн. Урсгал засвараар нийт 19 ажил төлөвлөж бүрэн хийж дуусгасан.</p>	
49.	3.1.2. Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг үе шаттайгаар засварлаж шинэчилнэ.	ДБТХ	<p>Нийслэлийн хөрөнгө оруулалтаар нийт 18 орон сууцны 23621 м<sup>2</sup> талбайн дээврийн засварыг 905.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэн, 2 орон сууцны 2 цахилгаан шатыг 81.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр шинээр угсарсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19-р хорооны “Тохилог- 21” СӨХ-ны 3 дугаар 58 айлын байр, 4а байр, “Дэлгэр-21” СӨХ-ны геологийн 5-30 дугаар байр зэрэг насжилт өндөртэй орон сууцны 24 байрны дээврийг засварлах ажил /1,25 тэрбум төгрөг/, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар “Өнөр-11” СӨХ-ны 3-р орц, “Их Мандал” СӨХ-ны 5-р байр, “Есөн-Эрдэнэ” СӨХ-ны 9-р орц, “Өнөр бүл” СӨХ-ны 22-р байрны 3-р орцны дээврийн засварын ажлууд тус тус хийгдсэн. 19-р хорооны “Сүрлэг-21” СӨХ-ны 8а байрны 1-р орц, 8в байрны 1, 5-р орцны цахилгаан шат зэрэг дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууцны байруудын 104 цахилгаан шатыг шинэчлэх ажил хөрөнгийн асуудлаас эхлэлийн байдалтай байна. Дүүргийн 9 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 28 СӨХ-дын 74 байрны 94603м<sup>2</sup> дээврийн талбайг засварлуулах нэгдсэн судалгааг гарган саналыг Барилга хот байгуулалтын яаманд 2015 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 02/1226 дугаар албан тоотоор хүргүүлсэн. Засвар хийгдэх шаардлагатай 52 СӨХ-дод албан шаардлага хүргүүлсэнээр 140 лифтний техникийн засвар үйлчилгээг СӨХ-д өөрийн хөрөнгөөр тус тус хийсэн.</p>	67,5
50.	3.1.3. Замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор авто замуудыг шинээр	ДБТХ	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт 43,4 км замын өргөтгөл шинэчлэлтийг улс, нийслэл, замын сангийн хөрөнгө оруулалтын 11,4 тэрбум төгрөгөөр, 3000 м<sup>2</sup> талбайн авто замын /нөхөөс гагнаас/ урсгал засварын ажлыг 141.0 сая төгрөгийн</p>	52.5

	барих, авто замын өргөтгөл хийх ажлыг зохион байгуулах, зам засварын ажлын чанарыг сайжруулна.		төсөвт өртгөөр хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хорооллын доторх автозамын засварын ажлыг 20 байршилд төлөвлөн, 5,9 км автозамыг шинэчлэн сайжруулахаар нэгдсэн жагсаалт гаргаж, саналаа нийслэлийн Авто замын газарт дүүргийн ЗДТГ-ын 2014 оны 3/173 дугаар албан бичгээр хүргүүлсэнээс 19 байршилд 5190 у/м авто замыг 2.070.0 сая төгрөгөөр засварласан. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 3, 8, 23, 31-р хороодод 205,4 сая төгрөгөөр авто зам сайжруулах ажил хийгдсэн.	
51.	3.1.4. Ард Аюушийн гудамжийг Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3.1 км замыг гүүрийн хамт барина	ДБТХ, ӨГХА	Баянгол дүүргийн 3-р хорооллын Ард Аюушийн гудамжийг дүүргийн 23, 30, 31 дүгээр хороодын нутаг дэвсгэрээр дамжуулан 19, 27 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3,1 км авто зам, 6 гүүрийн хамт баригдах авто замын трасст орсон 229 нэгж талбар, 100 байшингийн хөрөнгийн үнэлгээ, хөрөнгийн бүтэц, ангилалд судалгаа, үнэлгээ хийх ажлууд урд жилүүдэд хийгдсэн. 2015 онд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гудамж” төслийн хүрээнд авто замын ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна. Нийслэлийн 2014 оны төсвийн тодотголд тусгуулах талаар Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч Т.Болдбаатарт 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1189 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/312 дугаар захирамжаар байгуулагдсан Ард Аюушийн гудамжийг Толгойтын замтай холбох 3.1 км автозам байгуулах бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн трасст орсон 23, 30-р хорооны иргэдтэй уулзалт, хэлэлцүүлгийг 10-р сарын 25-ны өдөр ИТХ-ын Ажлын албатай хамтран хорооны иргэний танхимд зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үеэр иргэдийн сонирхсон асуултад хариулж, газрын үнэлгээний маягыг тараасан. Дээрх хороодын замын трасст орсон 111 иргэнээс санал асуулга авахад 44.1 хувь нь газраа байраар солих, 41.4 хувь нь мөнгөөр, 9,9 хувь нь чөлөөлөх боломжгүй, 3.7 хувь нь тухайн үед шийдвэрээ гаргах, 0,9 хувь нь өөр байршилд газраар солино гэсэн судалгаа гарсан байна. Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газарт “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д тусгуулахаар саналаа 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/754 албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтанд ороогүй тул концессын гэрээгээр хэрэгжих боломжгүй болсон. ОХУ, БНХАУ, Сингапур улсын хөрөнгө оруулалттай компаниудад хамтран ажиллах санал тавьсан боловч одоогийн байдлаар хариу ирээгүй байна.	22.5

52.	3.1.5. Ашиглалтын шаардлага хангахгүй хуучин орон сууцны барилгуудын газрын эрхийг бүртгэлжүүлж, оршин суугчдын оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг концессын гэрээгээр хийж гүйцэтгэнэ.	ДБТХ, ЭЗТХ	19-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 3-48 айлын байрыг буулгаж, барилгын ажлыг “Номтын-ам” ХХК гүйцэтгэж байна. Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газарт 1/1017 дугаар албан бичгээр уламжилж, “Цэргийн хотхон” орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажил 20-р хорооны Хуучин цэргийн хотхоны дан байруудын айл өрхийн 80%-нь зөвшөөрсөнөөр уг газарт Чогсэрд-ХХК хашаа татаж, улаан шугам тавих ажил хийгдсэн. 2015 Онд Дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууцны барилгуудын насжилт, газар хөдлөлтөнд тэсвэртэй байдлын судалгааг мэргэжлийн байгууллагаас авч, 19-р хорооны 2-20-р дан байр, 1-48-р орон сууц, Мах импексын үйлдвэрийн ажилчдын байр, 27-р хорооны тоосгоны 33-р байр, Тээврийн ажилчдын 12-1, 12-2-р байрыг “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалтай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаа”-нд хамруулах талаар иргэдийн уулзалт зохион байгуулж, нийт 91 айл өрхийн санал хүсэлтийг нэгтгэсэн. Мөн 18-р хорооны 5 шарын орон сууцны 18 иргэдээс ирүүлсэн өргөдлийн хамт НЕТГ-т хүсэлт гаргаснаар дээрх байршлуудаас НЕТГ-ын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтсээс 2015 онд дүүргийн нутаг дэвсгэрт тухайн барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэлтийн дүгнэлт гаргах судалгааны ажлын жагсаалтад орсон.	67.5
53.	3.1.6. Иргэдийг хямд үнэтэй орон сууц, амины орон сууцаар хангахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	ДБТХ, ЭЗТХ	1, 2, 20-р хорооны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд багтаж байгаа Хангамж, 1, 5-р баазын ажилчдын байр, төмөр замын дан байруудын оршин суугчдын дунд гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулахад “Хас харш” ХХК шалгарч Төслийн удирдах хорооноос батламжлагдан оршин суугчидтай 2 тал гэрээг 90 хувь, 3 талт гэрээг 50 хувь орчим байгуулан ажиллаж байна.“Хас Харш” ХХК нь эхний ээлжийн 2 блок 12 давхар 288 айлын орон сууцыг барих төлөвлөгөөтэй, Улаанбаатар хотын нэгдсэн шугам сүлжээнд холбогдохоор зургын ажлыг гүйцэтгэж байна. Мөн дээрх байршилд төсөл хэрэгжүүлэгч “Стандарт проперти” ХХК нь 28 айлын 2.3 га газрыг бүрэн чөлөөлөн төслийн эхний ээлжийн 262 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн 2015 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Улаанбаатар хотын нэгдсэн шугам сүлжээнд холбогдохоор зургийн ажлыг гүйцэтгэж дууссан. 5, 6, 7-р хорооны нутаг дэвсгэр Ханын материал орчим төсөл хэрэгжүүлэгч “Жиди” ХХК-ний инженерийн дэд бүтцийг бий болгох, барилгажилтын ажлыг эхлүүлэхэд эхний ээлжинд газар чөлөөлөх шаардлагатай газар эзэмших, өмчлөх эрхийн зөрчилтэй 40 айлын зөрчлийг нийслэлийн Засаг даргын А/405 дугаар захирамжийн дагуу	67.5

		<p>шийдвэрлүүлсэн. “Жи Ди” ХХК нь 23 айлын 2.0 га газрыг бүрэн чөлөөлөн 2015 онд төслийн эхний ээлжийн 116 айлын 9 давхар 2 блок барилга, Улаанбаатар хотын нэгдсэн дэд бүтцийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Мөн дээрх байршилд төсөл хэрэгжүүлэгч “Хера Пропертиз” ХХК нь цахилгааны дэд бүтцийн 1 комплектийг байгуулах 24-3 тоот айлтай гэрээ хийн газрыг чөлөөлөх шаардлагатай тул газар өмчлөх эрхийн зөрчлийг арилган шийдвэрлэсэн. Цахилгаан дамжуулах дэд бүтцийн 14 ТП-г ашиглалтанд оруулсан бөгөөд 2014 онд 14 айлын газрыг бүрэн чөлөөлж эхний ээлжийн 168 айлын орон сууцыг ашиглалтанд оруулсан. 2015 онд 20 айл, нийт 34 айлын 2.2 га газрыг бүрэн чөлөөлсөн, 332 айлын орон сууцыг ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. 10-р хороо Арьс ширний ажилчдын байр орчим төсөл хэрэгжүүлэгч “Назу проперти” ХХК нь 56 айлын 2.0 газрыг бүрэн чөлөөлөн 2015 онд ашиглалтанд оруулахаар эхний ээлжийн 74 айлын 5 давхар 1 блок орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлэн Улаанбаатар хотын нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг хийж гүйцэтгэж байна. Баянхошуу 28-р хороонд төсөл хэрэгжүүлэгч “ТОБ” ХХК-ний хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулах, техникийн нөхцөл гаргуулах болон инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулагдан хийгдэж байгаа болно. 2015 онд 30-р хорооны Хилчин хотхонд төсөл хэрэгжүүлэгч “Монгол дайван” ХХК нь 1,5 км автозам, хороолол доторх тохижилтын ажлыг дуусгасан бөгөөд амины сууцны жишиг хороолол болгохоор ажиллаж байна. Нийслэлийн гэр хороолол, орон сууцжуулах төсөлтэй хамтран гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар 10 хорооны /1, 2, 3, 4, 8, 23, 24, 25, 26, 27/ 5866 өрхийг хамруулан судалгаа явуулахад өмчлөл, эзэмшлийн газраа орон сууцаар солих-37.3%, инженерийн шугам, сүлжээ татуулах-31.8%, худалдах-2.7%, шийдээгүй-20.6%, хариулаагүй-7.7% гэсэн дүн гарсан байна. Дүүргийн хэмжээнд 22 хорооны 3500 гаруй иргэдэд гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар сургалт, ярилцлагыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж мэдээлэл зөвлөгөө өгсөн. 3, 4, 11, 22, 23-р хороодод 7 иргэдийн бүлэг шинээр байгуулагдаж тус бүлгүүдээс гарсан дахин төлөвлөлтөд хамрагдах хүсэлтийг Гэр хорооллын орон сууцжуулах төсөлд хүргүүлсэн. Иргэдийн бүлгээс гарсан саналыг үндэслэн тухайн байршилд нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагуудаар дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Газар шинэчлэн зохион байгуулалтын талаарх сургалтыг нийслэлийн Гэр хорооллыг орон</p>	
--	--	---	--



			сууцжуулах төслийн газартай хамтран дүүргийн иргэний танхимд зохион байгуулсан бөгөөд сургалтад Тамгын газрын холбогдох албан тушаалтан, гэр хороодын Засаг дарга, иргэдийн төлөөлөл хамрагдсан. Нийслэлийн гэр хорооллын орон сууцжуулах төслийн газартай хамтран нийт 8 удаа 600 гаруй иргэдэд газар шинэчлэн зохион байгуулалтын талаарх сургалтыг зохион байгуулснаар иргэдийн саналын дагуу 3-р хорооноос иргэдийн 2 бүлэг байгуулагдсан.	
54.	3.1.7. Гэр хорооллын өрхийн усны хүрэлцээ, хангамжийг сайжруулна.	ДБТХ	Орон нутгийн хөгжлийн сангийн болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 19 хорооны 24 байршилд усан сан, 8 байршилд гүний худаг, олон улсын байгууллагын тусламжаар 2 байршилд усан сан тус тус баригдсан.	75.0
55.	3.1.8. Гэр хорооллын эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг шинээр холбож, шаардлагатай газруудад хүчдлийг сайжруулна.	ДБТХ	6 хороонд цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр татах болон дэд станц барих ажил хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын хороодын цахилгаангүй 2860 өрх, хүчдэлийн уналттай 3311 өрхийн цахилгааны хангамжийг сайжруулах 34 төрлийн ажлыг 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Цахилгаан дамжуулах 6-10 Кв-ын кабелийн шугамыг шинэчлэх угсралтын ажил хийгдсэн. Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, Инженерийн байгууламжийн хэлтэстэй хамтран хүчдэл сайжруулах шаардлагатай гудамж, айл өрхүүдээр газар дээр нь очиж танилцан, гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд 6218 өрхийн цахилгаан хангамжийг сайжруулахаар зураг төсөв боловсруулах ажлыг 90,0 сая төгрөгөөр хийсэн.	52.5
56.	3.1.9. Баянхошуу, Орбит, Толгойтод орчимд орчин үеийн дэвшилтэт технологи бүхий дулааны станц, бохир усны гол шугамыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	ДБТХ, ЭЗТХ	Баянхошуу, Толгойт орчимд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжиж буй байршилд төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжүүдийн инженерийн шугам сүлжээний хийх ажлын талаар иргэдэд танилцуулах мэдээлэл өгөх уулзалтыг 4-р сарын 20, 25-нд 2, 10, 20, 28-р хорооны иргэний танхимд зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын А/175 дугаар захирамжаар “Сэлбэ, Баянхошууны дэд төвийн ариутгах шугам”-ын газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнд дүүргийн Засаг дарга орсон бөгөөд нөлөөлөлд өртсөн 4, 5, 7, 19, 26, 27-р хороодын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 77 нэгж талбарын судалгааг гарган төслийн багтай хамтран ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Баянхошуу, Сэлбэ дэд төвийн төслийн хүрээнд нийслэлийн Засаг даргын А/259 дүгээр захирамжийн дагуу 7 буудал, Баянхошуу бохир усны гол коллекторын гүйцэтгэгчээр “Хүрд” ХХК, “Б-Софт” ХХК тус тус шалгарсан.	52.5

57.	3.1.10. Гэр хороолол болон шинээр баригдах хороололд ахуйн үйлчилгээний цогцолбор барилга барина.	ДБТХ	2-р хорооны нутаг дэвсгэрт Орбитын 1-р гудамжны 4 тоотод иргэн Д.Даваа өөрийн хөрөнгөөр барилга барьж халуун ус, сауны зориулалтаар үйлчилгээ үзүүлэх хүсэлт ирүүлснийг дэмжин ажиллаж байна. НҮБ-ын “Хабитат” төслийн хүрээнд 30, 31-р хорооны нутаг дэвсгэрт ахуй үйлчилгээний цогцолбор баригдаж ашиглалтад орсон.	37.5
58.	3.1.11. Иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	ДБТХ	Авто үйлчилгээний талаархи судалгаа, саналыг жил бүр хороодоос авч нэгтгэн, Нийслэлийн тээврийн газарт хүргүүлж нийтийн тээврийн үйлчилгээний автобусны чиглэлийн тоог нэмэгдүүлэх талаар иргэдээс гаргасан хүсэлтийг Нийслэлийн тээврийн газарт уламжилснаар Нийтийн тээврийн үйлчилгээний шинэчлэлийн ажлын хүрээнд тойрог М:60 буюу Баянхошууны уулзвар - 3, 4 дүгээр хороолол - 1 дүгээр хороолол/ хойгуур, М60 /Б/ буюу Баянхошууны уулзвар - 1 дүгээр хороолол - 3, 4 дүгээр хороолол чиглэлүүдийг шинээр нээж автобусны зогсоолуудыг нэмэгдүүлсэн.Тахилтын чиглэлд том оврын 9 автобус /том оврын автобус үйлчилдэггүй байсан/, Баруун салаанаас Баянхошуу хойгуур ажлын өдөр 13 /урд нь 9 автобустай байсан/, урдуур 6, амралтын өдөр 4 том оврын автобус шугамаа уртасган Наран туул зах хүртэл үйлчилж байна. Зүүн салааны чиглэлд том оврын автобусны 1 ээлжийн үйлчилгээг 2 ээлж болгож нийтийн тээврийн том оврын автобусны тоог нэмэгдүүлсэн. 23-р хорооны Өндөр дэнж буюу Овоотын чиглэлд үйлчилгээ эрхэлж байсан “Сутайн буянт” компани гэрээ цуцалсан тул 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Эрийн хийморь компани 11 бага оврын автобусаар үйлчилгээ үзүүлж байна.	52.5
59.	3.1.12. Саппорогийн аюулгүй тойрог дээрх олон түвшний огтлолцол барих ажлыг эхлүүлнэ.	ДБТХ	Гудамж” төслийн хүрээнд Саппорогийн тойргийг дөрвөн замын уулзвар болгох ажлын зураг, төслийг “Танил санаа” ХХК, зам барилгын ажлыг “Наранбулаг Хан” ХХК тус тус хийж гүйцэтгэсэн.	100.0
60.	3.1.13. Толгойт Сонсголгонгийн замын уулзварт барих гүүрэн гарц барих ажлыг эхлүүлнэ.	ДБТХ	Сонсголгонгийн авто замыг “Арц суварга”, “Бадрах ойл” ХХК-иуд 23 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд тээврийн хэрэгсэл зорчих хэсгийг 16 метр өргөн, хажуугаараа дугуйн болон явган замтай, суурийн үеэс гадна бетон хучилтын зузаан нь 26 см байхаар тооцож шинэ технологиор барьж буй 5,5 км даацын шинэ замыг 2015 оны 09 дүгээр сард ашиглалтанд оруулсан.	100.0
3.2. Тохижилтын талаар				
61.	3.2.1. Иргэдийн ая тухтай амьдрах, чөлөөт цагаа зөв	ДБТХ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Хүүхдийн тоглоомын талбайг 2246.9 сая төгрөгийн төсөвт өртөгөөр 14 хорооны 20 байршилд, дүүргийн орон нутгийн	67.5

	зохистой өнгөрүүлэх орчныг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай газруудад бичил цэцэрлэг, усан оргилуур, тоглоомын талбай, нийтийн бие засах газар, явган хүний зам, гүүр, гарц барина.		хөгжлийн сангийн 782,4 сая төгрөгийн хөрөнгөөр 16 хорооны 16 байршилд байгуулсан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5 хорооны 10 байршилд явган хүний замыг 170.4 сая төгрөгийн төсөвт өртөгөөр, 9,10,24,26-р хороодод явган хүний 8 гүүр 165.7 сая төгрөгөөр, 12-р хороонд сагсан бөмбөг болон гар бөмбөгийн спорт талбай байгуулах ажлыг 42.7 сая төгрөгөөр, 18-р хороонд спорт талбайг 63.4 сая төгрөгөөр, 13-р хорооны 8,9-р байрны дунд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 59,9 сая төгрөгөөр, 14-р хорооны 38-р байрны зүүн урд, 12-р байрны хойд талд иргэдийн амрах талбайг 49,5 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулсан. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 3 хорооны 3 байршилд нийтийн бие засах газар барьж Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.	
62.	3.2.2. Дүүргийн томоохон гудамж, нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт хийнэ.	ДБТХ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 11 хорооны нутаг дэвсгэр дамнасан томоохон гудамж, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтыг 1893.0 /тэрбум найман зуун ерэн гурван сая/ сая төгрөгийн төсөвт өртөгөөр, 18-р хорооны нутаг дэвсгэр ҮЭ-ийн гудамжийг “Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ газар 4521 м2 талбайд 253,0 сая төсөвт өртөгтэйгээр явган хүний зам, ногоон байгууламж бүхий тохижилтын ажил хийсэн. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 22-р хорооны Орбитын тойрог орчмын нийтийн эзэмшлийн зам талбайд таксины зогсоол, нийтийн тээврийн буудал, явган хүний зам, гэрэлтүүлэг бүхий иж бүрэн тохижилтын ажлыг 161,1 сая төгрөгөөр, 5 хорооны 5 байршилд нийтийн эзэмшлийн зам талбайг 139,0 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус тохижуулан ашиглалтанд хүлээн авсан.	52.5
63.	3.2.3. Авто зам болон нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, дүүргийн нутаг дэвсгэр дэх рекламны байгууламжийг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан сайжруулан, орон сууц, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар асалтыг 95 хувьд хүргэнэ.	ДБТХ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Нийтийн эзэмшлийн Москвагийн гудамжинд 300, Үйлдвэрчний эвлэлийн гудамжинд 200, Зүүн салааны авто замын дагуу 156, Залуус гудамжинд 26, Барилгачин гудамжинд 16, Баянхошуу хойгуурхи 276 гэрэлтүүлгийг LED гэрэлтүүлэгчтэй болгосон. Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, асалтын байдалд сард 2-оос доошгүй үзлэг шалгалт явуулж байгаа ба гэрэлтүүлэгийн асалт тогтмол 92-97 хувьтай байна. Нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 21 хороонд 2.330.2 сая төгрөгөөр 43841 у/м газарт 1613 ширхэг гудамжны гэрэлтүүлэг тавьж ашиглалтад хүлээн авсан болно. 2013-2015 онд шинээр гэр болон орон сууцны хороололд хийгдсэн гэрэлтүүлгүүд 50-70 ваттын лед гэрэлтүүлэг болно. Зар сурталчилгааны байгууламжаас 2013 онд 102.3 сая, 2014 онд 105.6 сая, 2015 онд 114.7 сая төгрөгийн хураамжийг	67.5

			дүүргийн төсвийн орлогод төвлөрүүлсэн болно. 2013 онд Москвагийн гудамжны цагаан зурвасд байрлуулсан 104, дүүргийн нутаг дэвсгэрт байрлалтай стандарт бус, зөвшөөрөлгүй 48 рекламны байгууламжийг, 2015 онд Дүүргийн Засаг даргын 2015 оны 6-р сарын 11-ний өдрийн А/229 дүгээр захирамжаар нутаг дэвсгэр дэх стандарт бус, зөвшөөрөлгүй, хураамжаа төлөөгүй том, жижиг 78 байгууламж, хаягийг албадан буулгах арга хэмжээг дүүргийн замын цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулсан.	
64.	3.2.4. Автозам, орон сууцны доторхи зам, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээнд ахиц дэвшил гаргана.	ДБТХ	Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн 181350 м2 авто зам, 56120 м2 явган зам, хорооллын дундах 132269 м2 зам, 70770 м2 авто зогсоол, 537444 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээнд нийтийн эзэмшлийн зам талбайн 60 үйлчлэгч тогтмол ажиллаж байна. Цэвэрлэгээний байдалд 7-14 хоногт тогтмол хяналт тавин ажиллаж байна.	75.0
65.	3.2.5. Тусгай зориулалтын зам, шат, хаалга байгуулах ажлыг дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг нэмэгдүүлнэ.	ДБТХ	Нийслэлийн Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалт, тохижилтын ажлын хүрээнд Саппорогоос Таван шарын автобусны буудал хүртэл, Ханын материалын уулзвараас Баянхошууны тойрог хүртэл, Зүүн салааны явган хүний зам тохижуулж, тусгай зурваст хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зам тавьсан. “Иргэний барилга төлөвлөлт ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайг тооцож, хөгжлийн бэрхшээлтэй хүний явган зорчих стандарт”-ын дагуу чөлөөтэй бие даан зорчих, үйлчлүүлэх боломж нөхцлийг хангах үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын А/87 дугаар захирамжаар байгуулан дүүргийн нутаг дэвсгэрт шинээр баригдаж буй барилгын үйл явцтай танилцан, зөвлөмж тараан ажиллаа. Тамгын газрын байранд стандартын шаардлага хангасан налуу шатыг 4.2 сая төгрөгийн өртгөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Сонгинохайрхан бие даан амьдрах төв”-өөр хийлгэсэн.	37.5
66.	3.2.6. Дүүргийн цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.	ДБТХ, ӨГХА	2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 30-р хорооны нутаг дэвсгэр, Хамбын овоонд 158 га газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт уламжилснаар хэсэгчилсэн зураг, төсвийн ажлыг “Эрчим Арт” ХХК хийж гүйцэтгэсэн. 20-р хорооны нутаг дэвсгэрт “Авто худалдааны цогцолбор ” байгуулах ажлын хүрээнд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил хамт хийгдэхээр төлөвлөгдсөн.	37.5
67.	3.2.7. Тодорхой байршлуудад газар доорх болон давхар граж, авто зогсоол барих чиглэлээр	ДБТХ, ӨГХА	17-р хорооны иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулан, санал хүсэлтийг үндэслэн 32-33-р байрны голын талбайд тоглоомын талбай бүхий авто машины зогсоолыг “Дайчин Мугсу” ХХК хийж гүйцэтгэсэн. 1-р	52.5

	хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.		хорооллын 19-р байрны ар талд давхар граж бүхий хүүхдийн тоглоомын талбай байгуулах тухай нийслэлийн Засаг даргын захирамж гарсан. Дүүргийн 15-р хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар иргэдийн дунд хэлэлцүүлэг хийсэн боловч дэмжлэг аваагүй байна.	
Дөрөв. Экологи-байгаль орчныг хамгаалахад ахиц дэвшил гаргана.				
68.	4.1. Дулааны төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрээр хангах боломжгүй гэр хорооллын айл өрхүүдийг эрчим хүчний хэмнэлттэй зуух, боловсруулсан түлш болон утаа шүүгчээр хангаж халаалтын зуухнуудын тоног төхөөрөмжийг шинэчилнэ.	ДБТХ	“Бүрэн шаталттай зуухны төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Rayol ocean” маркийн “Дөл” зуух 3519, “Өлзий” зуух 1586, “Векас-107” маркийн зуух 277, “Талст” зуух 4, нийт 5383 айл өрхөд ердийн халаалтын зуухыг иргэдэд хөнгөлөлттэй үнээр борлуулсан. 2014 онд хөнгөлөлттэй зуух авах иргэдийг цахимаар бүртгэж хязгаарлалтын бүсэд орсон 4884 айл өрх хөнгөлөлттэй үнээр зуух авах эрх үүссэн. “Хүрд” ХХК-ны Канад усан халаалтын зуухны борлуулалт хийж, 581 өрхөд суурилуулаад байна. Цахилгааны үнийн хөнгөлөлтөнд 20427 айл өрх хамрагдаад байна. НАЧА, МХГ-уудтай хамтран Агаарын бохирдлын эх үүсвэрийг бий болгож буй ил галлагаатай дугуй засварын газрууд, ТҮЦ, павилонуудад хяналт шалгалтыг явуулж, 6 дугуй засварын газар, 2 ТҮЦ-д Мэргэжлийн хяналтын байгууллагаас хугацаатай албан мэдэгдэл өгч, зөрчлийг арилгуулсан. Хяналт шалгалтын дүнг үндэслэн зөрчил дутагдлыг цаашид гаргуулахгүй байх, гарч болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор “Зөвхөн Зуух” өдөрлөгийг Баянхошууны эцэс БОСА төвийн байранд “УБ-Цэвэр агаар” төслийн нэгж, Захирагчийн ажлын албаны Баянхошуу дахь албатай хамтран зохион байгуулсан. “Халаатын зуухны байгууламжийг магадлан итгэмжлэх тухай” журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор нийслэлийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд зохион байгуулсан шалгалтаар албан шаардлага авсан ААНБ болон халаалтын зуух үйлдвэрлэгч нарт Нийслэлийн агаарын чанарын алба, Мэргэжлийн хяналтын алба, ЖАЙКА ОУБ-тай хамтран галлагааны горим, түүнээс улбаатай агаарын бохирдолд нөлөөлөх нөлөөллийг багасгах арга хэмжээний талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан судалгааны маягтын дагуу агаарын бохирдолтын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах журмын дагуу тоо бүртгэл явуулж дүнг нэгтгэсэн. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дулаан баригч бүтээгдэхүүнийг гэр хорооллын айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр борлуулахаар дүүргийн Засаг даргын Тамгын газар газар Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь салбартай “САНАМЖ БИЧИГ”-ийг байгуулж, 2015 онд хэрэгжүүлэх 14 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган	75.0

			батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	
69.	4.2. Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий талбайд нөхөн сэргээлт, арчилгаа цэвэрлэгээ хийнэ.	ДБТХ	Дүүргийн нутаг дэвсгэр Хүй долоон худаг орчимд ойн зурвас байгуулах гүйцэтгэгчээр “Цэцэрлэгжилт” ХХК, 21 дүгээр хорооны Төмөр замын 361 гарам орчим ойн зурвас байгуулах гүйцэтгэгчээр “Ногоон харш” ХХК-иуд шалгаран ажиллаж байна. Дүүргийн 21-р хорооны Хөндлөнгийн аманд 50 га газарт “Мон таксац” ХХК шинээр 2-3 настай нарс, шинэс модны суулгац тарьсан бөгөөд ойжуулалтын ажлын амьдралын хувийг тооцож хүлээн авсан. 21-р хорооны нутаг дэвсгэр Нарийны фермийн Хөндлөнгийн аманд ойн түймэр болон огтлолтонд өртсөн нарсан ойн 40 га талбайг ойжуулах 27.567.950 төгрөгийн санхүүжилт бүхий тендерт “Вэбтүүн” ХХК шалгарч Шинэс, нарс модны 2 настай тарьцыг 1м х 4м хэмжээтэй схемээр гар аргаар 1 га талбайд 2500 ширхэг нийт 100000 ширхэг тарьц суулган намрын тооллого хийхэд 1 га-д 1910 ширхэг нийт 76400 ширхэг ургасныг тогтоож, Нийслэлийн Байгаль орчин ногоон хөгжлийн газраас томилогдсон ойжуулалтын ажлыг шалгаж хүлээн авах комисс актаар хүлээж аваад байна.	67,5
70.	4.3. Ногоон бүсийн хортон шавьж, өвчний тархалтын судалгаа хийж, хортон шавьж өвчний устгалыг 2000 га талбайд хийнэ.	ДБТХ	Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт дүүргийн ЗДТГ-ын Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн даргын 2014 оны 3/ 532 дугаартай албан тоотой ойн сан бүхий газарт хортон шавьжийн өвчний тархалтын талаар судалгаа хийлгүүлэх хүсэлт хүргүүлсэн ба 2015 онд Ойн судалгаа хөгжлийн төвөөс дүүргийн нутаг дэвсгэрийн ойн сан бүхий тодорхой талбайд хөнөөлт хортон шавьжийн тархалтын байдалд судалгаа хийснээр устгалын ажил хийх шаардлагагүй гэж үзсэн.	75.0
71.	4.4. Нутаг дэвсгэрийн ногоон бүсийн тодорхой хэсгийг иргэдийн нөхөрлөлд хариуцуулах ажлыг судлан шийдвэрлэнэ.	ДБТХ	Иргэн Г.Баатар, Д.Доржсүрэн, Т.Бямбасүрэн нараас ногоон бүсийн тодорхой хэсгийг хамгаалах зорилго бүхий нөхөрлөл байгуулах санал ирүүлсэн боловч дүүргийн ИТХ иргэдээр нөхөрлөл байгуулан ногоон бүсийг хамгаалуулах шаардлагагүй гэж үзэж шийдвэр гаргаагүй болно. 2013, 2014, 2015 онуудад дүүргийн нутаг дэвсгэрийн ойн сан бүхий 13 байршилд ногоон бүс хамгаалах зорилго бүхий морин эргүүлийг дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй гэрээ байгуулан ажиллуулсан.	37.5

72.	4.5. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах булаг, шанд, нуурын орчныг тохижуулж, хамгаалалтанд авах, ногоон бүс бүхий уулын амуудад байгаль орчны орон тооны бүс байцаагчийн тоог нэмэгдүүлэх	ДБТХ	Нийслэлийн төсвийн 460,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Гуулин тал” ХХКомпани Гүнжийн нуурыг сэргээн засварлаж, “ЛХА-АМИР” ХХК Бөөр булгийг хашаа, хайс барьж тохижуулан тус тус ашиглалтанд хүлээлгэн өгсөн. Улаан чулуутын талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулдаг “Ялгуусан” ХХК өөрийн хөрөнгөөр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд дүйцүүлэн хамгаалах байдлаар 26 дугаар хорооны Нарангийн булгийн эхийг хамгаалж хашаа, хашлага хийж тохижуулсан. “Төгс хурц консалтинг” ХХК 21-р хорооны Ар тахилтын амны булгийг шинээр тохижуулж, 25-р хорооны Ухнын амны булгийн хайс хашааг сэлбэж засварласан.	52,5
73.	4.6. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хайрга, шаврын орд ашигладаг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд жил бүр үзлэг, шалгалт явуулан, стандартад нийцэхгүй ордуудын үйл ажиллагааг зогсоох, нөхөн сэргээлтийг тусгай төлөвлөгөөний дагуу хийлгэнэ.	ДБТХ, МХХ	Сонгинохайрхан уулын зүүн бэлд нэр бүхий 13 компани түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байсан, нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас байгальд их хэмжээний хохирол /нийт хохирлын хэмжээ 8.8 тэрбум төгрөг/ учруулсныг илрүүлэн, уг газрыг дүүргийн тусгай хамгаалалтын газар болгон ашиглахаар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан. Нийслэлийн Байгаль орчин ногоон хөгжлийн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэр дээр авто замын хайрга, дайрга, барилгын материал ашиглах явцад эвдэрсэн дараах газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлгэсэн. Үүнд: 32-р нутаг дэвсгэрт “Тэгш плант” ХХК, “Эрдэнэ зам” ХХК, “Анандын зам” ХХК, “Хэрэмт цамхаг” ХХК-д 60,67 га газарт, 21-р хорооны нутаг дэвсгэрт “Баткубик” ХХК, “Төгс зам” ХХК-д 6,8 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн. “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар Тахилтын амнаас хар шороо авч ашигласан 2,5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийлгэж хүлээн авсан. 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Хүй долоо худаг чиглэлийн 8,5 км авто зам тавихад авч ашигласан Төмөр замын 361 дүгээр гарамын баруун урд хэсгийн түр карьерийн 2,1 га талбай, Жаргалант-Батсүмбэр чиглэлийн 17 км хатуу хучилттай авто замын ажлын далангийн дүүргэлтэнд ашигласан 10,5 га талбайн техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийлгэж хүлээн авсан. НМХГ-ын даргын баталсан “Хайрга, дайрга, элс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02-01/134 тоот удирдамжийн дагуу 3 аж ахуйн нэгжийг хяналт шалгалтанд хамруулсан. Нийслэлийн Аудитын газартай хамтран 2015 оны төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний дагуу түгээмэл тархацтай ашигт	75,0

			малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын үр дүн”-д аудит хийлгэж дүгнэлт гаргаад байна. Дүүргийн МХХ, ТХ-үүдтэй хамтран аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан хяналт тавьж ажиллалаа. Дүүргийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа 16 аж ахуйн нэгж байгууллагуудаас 11 ААНБ хөрөнгө санхүү, бусад шалтгааны улмаас 2015 онд үйл ажиллагаагаа зогсоосон байна.	
74.	4.7. Хөрс, ус, орчны бохирдлыг багасгахад гадаадын төслийн дэмжлэг авч хамтран ажиллана.	ДБТХ, МХХ	Туул голын сав газрын захиргаатай хамтран иргэдийн ундны болон ахуйн хэрэгцээндээ ашиглаж байгаа булаг, шанд, уст цэгийг тоолж баталгаажуулах ажлыг хийсэн. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа 91 булаг шанд, гүний худгаас дээж авч шинжлүүлэн 15 дүгнэлт, 1 акт, 1 албан шаардлагаар үүрэг өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Нийт 52 ус түгээх байрны уснаас болон савнаас дээж аван шинжлүүлж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “Эрүүл орчин-эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг бохирын цооногтой болгох зорилгоор “Эрүүл цэвэр орчинд амьдарцгаая” сэдэвт 2.4 сая төгрөгийн шагналын сан бүхий болзолт уралдааныг хороодын хэсгийн ахлагчдын дунд 3 сарын хугацаатай зарлан дүгнэсэн. Зуслан, ногоон бүсийн хур болон үүсмэл хог хаягдлыг цэвэрлэх ажлыг Эко бүлгийн 20 гишүүн хийж гүйцэтгэн, хөрсийг ариутган халдваргүйжүүлэх, жорлон муу усны нүхийг ариутгах ажлын хүрээнд Толгойтын Зүүн салааны зуслангийн 723 өрхийн жорлон муу усны цооногт ариутгал халдваргүйтгэл хийгдсэн. Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Азийн сан ТББ-тай хамтран Гэр хорооллын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн 2015 оны 4 дүгээр сар хүртэл хийсэн ажлын үр дүнг тооцож МҮТВ-ээр нэвтрүүлэг 1 удаа хийсэн. Азийн сантай хамтран хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудтай хийх гэрээг шинэчлэн хийж, гэр хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх иргэдийн 3 бүлгийг 55 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан 8-р сараас эхлэн ажиллуулж хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд сар тутам 38,2 сая төгрөгийн санхүүжилтийг нийслэлийн төсвөөс авч байна. Гэр хорооллын бохирын цооног, ОО-ыг ариутгах, хөрсний ариутгал хийх ажлыг хийлгэхээр “Бакс анд”, “Орхон овоот” ХХК-ниудтай гэрээ байгуулж, 5, 7, 23 дугаар хороодын нутаг дэвсгэрийн 36817 м/кв талбайд хийж гүйцэтгэсэн.	52.5



75.	4.8. Хог хаягдлыг тээвэрлэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, Тээвэрлэлт үйлчилгээний төв, Нийтлэг үйлчилгээний төв, Тохижилт үйлчилгээний компаний материаллаг баазыг нэмэгдүүлэн хур хогийн цэггүй дүүрэг болно.	ДБТХ	Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 14 дүгээр тогтоолын дагуу Тохижилт үйлчилгээний компанийг төрийн мэдэлд шилжүүлэн Тохижилт цэвэрлэгээ, үйлчилгээ Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилсөн. Хог тээвэрлэгч байгууллагыг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журмын дагуу дүүргийн хог хаягдлыг ачиж цэвэрлэх, тээвэрлэх аж ахуйн нэгж байгууллагаар Тээвэрлэлт үйлчилгээний төв, Нийтлэг үйлчилгээний төв, Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд шалгаран үйл ажиллагаа явуулж байна. Тээвэрлэлт үйлчилгээний төвийн гражийн барилгын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилт, 2015-2017 оны хөрөнгө оруулалтын ажлын саналд /0.5 тэрбум төгрөг/тусгуулахаар дүүргийн Засаг даргын 1/1020, 1/1029 тоот албан бичгээр нийслэлийн Засаг дарга, НЗДТГ-т хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдлыг тээвэрлэх орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын автопаркын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Солонгос улсад үйлдвэрлэсэн задгай тэвштэй 15 тн-ийн даацтай Daewoo маркийн автомашин 5, Hyundai маркийн тусгай зориулалтын 5 тн-ын даацтай автомашин 2 ширхгийг тус тус Нийслэлийн хөрөнгө оруулалтаар, тусгай зориулалтын Nissan hino маркын хог тээврийн автомашин 2, жижиг оврын трактор 1-ийг Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлээс, LG933L маркын ковш 1-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр авсан. Дүүргийн нутаг дэвсгэрийн хог хаягдал тогтмол үүсдэг 13 байршлын судалгааг гарган 20-р хорооны нутаг дэвсгэрт Төгс зуурмаг ХХК-ны зүүн талын 100 м/кв талбайн хог хаягдлыг Улаанбаатар шинэчлэл ХХК-аар цэвэрлүүлэн камержуулах ажил хийгдсэн.	67,5
<b>Тав. Нутгийн захиргааны байгууллагын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгоно.</b>				
76.	5.1. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод байлган, иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэн, нутгийн захиргааны байгууллагын шийдвэрт иргэдийн санал бодлыг тусган хэрэгжүүлж, төрийн боломжит зарим үйлчилгээг төрийн бус	ЗХХ	2013-2015 онд Засаг даргын захирамж, албан даалгавар 470, шуурхай зөвлөгөөний талаарх мэдээлэл 114, хороодын тулгамдсан асуудал 7, төсөв санхүүгийн ил, тод байдал 57, ЗДТГ-ын санхүүгийн ил тод байдал 26, тендерийн зар 232, тендерийн үйл явц 17, тендерийн үр дүн 9, тендерийн журам, заавар 8, тендерийн жишиг баримт бичиг 11, таны хөтөч 17, хүний нөөцийн талаар 27, ёс зүй авлига 18, ИТХ-ын 131, Засаг даргын уулзалт 14, дээд байгууллагын ирүүлсэн тогтоол, шийдвэр 14, дотоод үйл ажиллагааны 10, ТББ-ын жагсаалт, 16, дэд хөтөлбөр 3, Тусгай зөвшөөрөл 32, цаг үеийн холбогдолтой 624, бусад 121, нийт 1665 мэдээ, мэдээллийг <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a>	75.0

	байгууллагуудаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлан ажиллана.		<p>цахим хуудсанд байршуулсан. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй хүргэх зорилгоор Тамгын газрын байрны урд талд “ЛЕД” дэлгэц, байрлуулсан Тамгын газрын байрны өргөтгөлийн 3-р давхрын 30 м<sup>2</sup> талбай бүхий өрөөг тохижуулан үнэлгээний хороодын хуралдааныг ил тод, нээлттэй явуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. 2014 онд 5, 8, 19, 20, 21, 22-р хороодод тавилга шинэчлэхэд 22,1 сая, 7, 19, 20, 21-р хороодын үйлчилгээний заалны багтаамж нэмэх, барилгын засварын ажилд 25,6 сая, 32 хороог урсдаг мэдээллийн самбар, скайнерт 23,1 сая, нийт 70,8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд 84 хүний суудалтай иж бүрэн тоног төхөөрөмж бүхий дүүргийн иргэний танхим байгуулж Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 22 хорооны иргэний танхимыг тус тус тохижуулан, 2014, 2015 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажил, “Иргэдийн оролцоотой төсөв-2014”, “Манай хороо-Миний оролцоо”, “Согтууруулах ундааны хяналтын тухай хууль”, “Иргэдийн эко форум”, “Захиргааны ерөнхий хууль” “Төрийн албаны тухай хууль”, “Хөршийн хяналт холбоо” болон тоосгоны үйлдвэрүүдийг дүүргийн нутаг дэвсгэрээс гаргах зэрэг хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг нутгийн захиргааны байгууллагын шийдвэрт тусган ажиллаж байна. 2013 онд 596.243, 2014 онд 641.708, 2015 онд 478698 нийт 1716649 иргэнд төрийн үйлчилгээг Нэг цонхны үйлчилгээгээр хүргэсэн.</p> <p>2013 онд 12, 2014 онд 7, 2015 онд 2-р хороог Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Нэг цонхны үйлчилгээний хэлбэрт шилжүүлсэнээр нийт хороодын 28 буюу 87,5 хувийг шийдвэрлэв. Хүний нөөцтэй холбогдолтой мэдээлэл, хороодын хэсгийн ахлагчийн ажлын байрны зарыг Төрийн албаны салбар зөвлөлийн <a href="http://www.csc.gov.mn">www.csc.gov.mn</a>, дүүргийн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудсанд тухай бүрд нь шинэчлэн, байршуулж, 2013-2015 онд дүүргийн ЗДТГ, хороодод гарсан төрийн жинхэнэ албан хаагчийн 6 сул орон тоог нээлттэй, ил тод зарлан, 1670 иргэн бүртгүүлж, мэргэшлийн шалгалтанд тэнцсэн, 253 иргэнийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэсэн. Иргэдийн эд хөрөнгийн эрхийн гэрчилгээг Монгол шуудан ТӨХК-тай хамтран иргэн хүссэн хаягаараа хүлээн авах төлбөрт үйлчилгээг нэвтрүүлсэн нь цаг хугацаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй иргэдийн талархлыг хүлээсэн үйлчилгээ болсон. Засаг даргын нөөц хөрөнгө болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран холбогдох</p>	
--	--	--	---	--

			зардлыг шийдвэрлүүлэн бага орлоготой, өрх толгойлсон эмэгтэйчүүд , эмзэг бүлгийн, нэн ядуу, ажилгүй, бичиг баримтгүй нийт 600 орчим иргэнийг бүртгэлд хамруулж баримт бичиг олгох ажлыг зохион байгуулав. “Шилэн дансны тухай” хууль, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоол, журмыг хэрэгжүүлж, дүүргийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийг сар бүр хуулийн хугацаанд нь шинэчилсэн <a href="http://www.shilendans.ub.gov.mn">www.shilendans.ub.gov.mn</a> болон <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудсанд байршуулж, дүүргийн хэмжээнд 150 байгууллага, аж ахуйн нэгж бүртгүүлэн, мэдээллээ бүрэн, гүйцэд шивж оруулсан. Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр, Төрийн боломжит зарим үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх чиглэлийн хүрээнд 28 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж, 6423 иргэнийг хамруулсан.	
77.	5.2. Шинээр дүүрэг байгуулах асуудлыг боловсруулан саналыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.	ЗХХ	Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн А/163 дугаар тогтоолоор дүүргийг хуваан шинээр дүүрэг байгуулах асуудлыг судлан, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын эдийн засаг, санхүү, төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогчоор ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Шинээр дүүрэг хуваах асуудлыг дэмжих эсэх асуудлаар 32 хорооны 31.4 мянга орчим иргэдийн дунд /өрхийн 48.1%, нийт хүн амын 12.0%, 18-аас дээш насны хүн амын 17.9 хувийг хамруулан/ асуулга зохион байгуулахад 74.8 % нь тийм, 25.2% нь үгүй гэсэн санал өгсөн байна. Шинээр дүүрэг байгуулахад шаардагдах төсөв зардлын тооцоо, өрх, хүн амын тоог харгалзан 2 хувилбар боловсруулан дүүргийн ИТХ-ын Ажлын албанд хүргүүлсэн.	75.0
78.	5.3. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ.	ЗХХ	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудасны “Ил тод” цэсэнд “Хуулийн зөвлөгөө” дэд цэс үүсгэн иргэдэд цахимаар хууль, эрх зүйн зөвлөгөөг өгч байна. “Тусгай зөвшөөрөл” цэс үүсгэж төрийн үйлчилгээг авахад шаардагдах материалын жагсаалтыг байршуулж, <a href="http://www.smartcity.mn">www.smartcity.mn</a> сайтаар иргэдийн санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. ЗДТГ-ын утгах үйлчилгээний танхимд цахим хуудсанд суурилсан “Төрийн үйлчилгээний ухаалаг дэлгэц” байрлуулсан бөгөөд иргэд төрийн үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын жагсаалт, мэдээ мэдээлэл авахаас гадна, өөрийн цахим шуудан руу илгээх, хэвлэх боломжийг бүрдүүлсэн. Дүүргийн хэмжээнд 2013-2015 онд 11 ТҮЦ машиныг байршуулан тайлант хугацаанд 624.0 мян иргэн иргэний бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр 16 нэр төрлийн лавлагаа, мэдээлэл олгосон байна. Е бирж хөдөлмөрийн 31 цахим машиныг дүүргийн ЗДТГ,	67.5

			<p>хороод, Татварын хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсийн байранд тус тус байршуулж, 15602 иргэнд хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны зар сурталчилгааны талаарх мэдээллээр хангаж үйлчилсэн. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 80853 хувийн хэргийг цахимжуулаад байна. Дүүргийн 31 хороо шилэн кабельд, 28 хороо иргэний бүртгэлийн онлайн систем болон бусад цахим сүлжээнд холбогдож, шилжилт хөдөлгөөн, гэрлэлт, гэрлэлт цуцалсан /шүүхийн журмаар/, гэрлэлт сэргээсэн, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээний дахин олголт, иргэний үнэмлэх, оршин суугаа хаяг, лавлагааны зэрэг 10 төрлийн үйлчилгээг хорооны түвшинд хүргэж, бүртгэлийн үйлчилгээг цахим сангаас иргэнд шуурхай үзүүлэх боломжтой болсон. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлэн байршуулсан иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл солилцох нөхцлийг бүрдүүлж ТҮЦ машинаар дамжуулан эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй эсэх лавлагаа, иргэний үнэмлэх дахин авах хүсэлт илгээх зэрэг нэмэлт үйлчилгээг үзүүлж байна. <a href="http://www.manaikhoogo.mn">www.manaikhoogo.mn</a> цахим хуудсыг дүүрэг, хороодын түвшинд мэдээлэл оруулах, хүссэн мэдээллээ цахим хэлбэрээр харж, дүн шинжилгээ хийх, газрын зураглалд тэмдэглэгдсэн үзүүлэлтүүдийг өөрийн хүссэн сонголт, хэлбэрээр харах, иргэд өөрсдийн санал хүсэлтийг илгээх, мэдээлэл оруулах боломжтойгоор боловсруулан өргөтгөн шинэчлэх ажил хийгдэж дууссан.</p>	
79.	5.4. Дүүргийн нутгийн захиргааны ордон барина.	ЗХХ, ӨГХА	<p>Нутгийн захиргааны ордон барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр дүүргийн Засаг даргын 2014 оны 1/1047, 2015-2017 оны хөрөнгө оруулалтын ажлын саналд тусгуулахаар дүүргийн Засаг даргын 1/1029 тоот албан бичгийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/406 дугаар захирамжаар Цагдаагийн 1-р хэлтсийн түр саатуулах байр байрлах 0,1 га газрыг дүүргийн нутгийн захиргааны ордон барих зориулалтаар Тамгын газарт эзэмшүүлсэн байна. Уг байрны зураг, төсөв хийлгэх зардал 200.0 сая төгрөгийг нийслэлийн төсвийн тодотголоор батлуулан, зураг, төсвийг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын 2014 оны А/207 дугаар захирамжаар байгуулан тендер зарласан байна. Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 9-р хуралдаанаар дүүргийн цагдаагийн 1-р хэлтсийн өмнөх эрүүлжүүлэх байрыг буулгаж, барихад шаардагдах 410.0 сая төгрөгийг шийдвэрлэж баталсан. Нутгийн захиргааны ордны зураг</p>	67.5

			төсвийг хийлгэх зөвлөх үйлчилгээний тендерийг сонгон шалгаруулж, нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2015 оны 1-р сарын 16-нд хүргүүлсэн бөгөөд төсөв мөнгөгүй шалтгаанаар тендер буцаагдсан. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын төсөлд тусгуулахаар саналаа дүүргийн Засаг даргын 2015 оны 01/1273 тоот бичгээр хүргүүлсэн.	
80.	5.5. Бүх хороодыг цогцолбор байртай болгоно.	ЗХХ	2013-2014 онд 1, 4, 5, 10-р хороодын цогцолбор байр ашиглалтанд орж, 2015 онд 2, 3, 9-р хорооны цогцолбор байрыг барьж, ашиглалтанд авсан. 11-р хорооны цогцолбор байрны барилгын ажил он дамжин 2016 онд ашиглалтанд орно. Нийт хороодын 90 хувь нь буюу 29 нь цогцолбор байртай болж, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна.	67.5
81.	5.6. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх талаар сургалт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	ЗХХ	Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын удирдах албан тушаалтнууд, Тамгын газрын төрийн албан хаагчид, иргэдэд 4 удаагийн зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Авлигын эсрэг үйл ажиллагааны тухай “ХАСХОМ мэдүүлэгчдэд зориулсан сургалт”, “Шударга монгол хүний 7 дадал”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт болон бусад хууль тогтоомж, холбогдох журмын талаар хийгдсэн 21 удаагийн сургалтанд 182 хаагчдыг хамруулж гарын авлага, товхимол, хэвлэмэл хуудсыг тараасан. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2015 оны 4-р сарын 21-ний өдөр холбогдох хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах зорилгоор дүүргийн төсвийн байгууллагуудын 32 удирдах албан хаагчдын дунд Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын эсрэг хамтдаа-2015” АХА тэмцээнийг зохион байгуулсан. Дүүргийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт /Шилэн уулзалт/-д ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”, Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, төрийн байгууллагуудад зөвлөмж хүргэн ажилласан. 2013 онд 121, 2014 онд 190, 2015 онд 37 төрийн жинхэнэ албан хаагчдын ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд хүлээн авч бүртгэн <a href="http://www.meduuleg.iaac.mn">www.meduuleg.iaac.mn</a> сайтад байршуулж, 2013-2015 онд 1212 мэдэгдэл, тайлбар гаргасан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 117 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг бүрдүүлэн Авлигатай тэмцэх газраар хянуулсан.	75.0
82.	5.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, дээрх ажилд иргэд, олон нийтийн	ЗХХ, ЦХ I, II хэлтэс	Цагдаагийн албаны тухай шинэ хуулиар цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор цагдаагийн 3 хэлтсийг байгуулан, 1, 2-р хэлтсийн барилгын өргөтгөл, байрыг ашиглалтад оруулсан. Орон	67.5

	оролцоог нэмэгдүүлнэ	<p>нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин 2014 онд 30.0, 2015 онд 30.0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж, авто машин олгож, дэмжлэг үзүүлсэн. Дүүргийн хэмжээнд 2014 онд 38, 2015 онд 9, нийт 47 олон нийтийн цагдаагийн ажилтан томилогдон ажиллаж байна. Хороодын хүн амын нягтаршил, газар нутгийн онцлог, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан 14 олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоо, урамшууллыг нэмэгдүүлэх саналыг дүүргийн Засаг даргын 2015 оны 02/1479, 01/2158 тоот албан бичгээр Улаанбаатар хотын Цагдаагийн газарт хүргүүлсэн. 2014 онд дүүргийн хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд “Цагдаагийн албаны хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг дүүргийн ИТХ-ын ажлын алба, хууль, хяналтын байгууллага, хороодын Засаг дарга нарыг оролцуулан 2 удаа хийв. Хууль зүйн яам, дүүргийн ИТХ, Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэстэй хамтран, эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээний холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлах зорилгоор 2015 оны 9-р сард “Иргэн ба хууль” арга хэмжээг зохион байгуулж, 10 төрлийн 1600 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж, гарын авлагыг тарааж, 122 иргэний санал, хүсэлтийг бичгээр хүлээн авч, холбогдох газарт уламжилсан. Архи тамхи, мансууруулах эм, бодисын зүй бус хэрэглээ, түүний хор уршгаас урьдчилан сэргийлэх зорилгоор Ерөнхий боловсролын 22 сургуулийн ахлах, төгсөх ангийн 3100 орчим сурагчид болон өсвөр насныханд “Мансууралгүй ирээдүй, “Хар тамхи, мансууруулах бодис түүний хор уршиг” сэдвээр сургалт зохион байгуулж, 3200 сурталчилгааны материал тараасан. Холбогдох хууль тогтоомжуудын талаар мэдээлэл өгөх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хорих газраас суллагдсан, хяналтанд байдаг 123 иргэнд “Хорих газраас суллагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжье”, “Иргэн-нийгэмшил” сэдэвт уулзалт, өдөрлөг зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулга хийн, 65 иргэнийг мэргэжлийн сургалтанд хамруулж 9 иргэнийг ажлын байраар хангасан. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/450 дугаар захирамжийн хүрээнд “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар суллагдсан 277 иргэдийг Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн төв, Улаан загалмайн хороо, Бүртгэлийн хэлтэстэй хамтарч бүртгэлжүүлэх, нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах, сэтгэлзүйн зөвлөгөө өгч, ажил хөдөлмөрт зуучлах, байршуулах ажлыг зохион байгуулсан. Гэмт хэргээс урьдчилан</p>	
--	----------------------	---	--

			<p>сэргийлэх чиглэлээр “Сэрэмжлүүлэг”, “Зөвлөмж” , “Орон байр” “Сэргийлцгээе”, “Хараа хяналт” “Хяналт”, “Сар шинэ”, “Оюутан эргүүл”, “Хүүхэд хамгаалал” зэрэг 28 эргүүл, хяналтын нэгдсэн арга хэмжээг 560 төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчид, их, дээд сургуулийн төгсөх ангийн оюутнуудын оролцоотой зохион байгуулав. “Хөршийн хяналт” хөтөлбөр, журмыг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор Цагдаагийн 3-р хэлтэс, 32 хорооны 256 алба хаагчид, хэсгийн ахлагч нартай хамтран “Хөршийн өдөр” арга хэмжээг зохион байгуулж, 1536 орчим орчим иргэдийг хамруулан, сурталчилгааны 3875 ширхэг материалыг тараасан. Арга хэмжээний хүрээнд 1, 2, 4, 18, 19, 20, 21, 26, 27, 32-р хороодын иргэдийн санаачилгаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий сайн дурын 36 бүлгэмийг шинээр байгуулсан. Дүүргийн Засаг даргын 2015 оны А/369, А/370 дугаар захирамжаар Олон нийтийн цагдаа, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эргүүлийн ажилд 2300 орчим иргэн, 250 аж ахуйн нэгж, байгууллагуудыг 450 чиглэлд татан оролцуулж, хулгайн болон бусад төрлийн гэмт хэрэг буурсан 4, 18, 26-р хороодын Засаг дарга, хэсгийн байцаагч Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийг тус тус шалгаруулж урамшуулсан.</p>	
83.	5.8. “Архигүй баасан гараг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	ЗХХ	<p>Дүүргийн Засаг даргын 2013 оны 311 дүгээр захирамжаар “Архигүй баасан гараг” дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан хөтөлбөрийг боловсруулж, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны А/11 дүгээр тогтоолоор батлуулсан ба хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2014 оны А/95 дугаар захирамжаар томилж 2014, 2015 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг тооцоход 86.5 хувьтай байна. Дүүргийн ГХУСАЗЗ, Хороодын Засаг дарга нартай хамтран “Архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах нь” сэдвээр сургалт зохион байгуулж, нутаг дэвсгэрийн 485 аж ахуйн нэгж байгууллага, 1320 иргэдийг хамруулан, 1500 ширхэг эмхэтгэл, гарын авлага тараасан. Хөтөлбөрийн хүрээнд иргэдэд архи, тамхины хор хөнөөлийг ойлгуулан таниулах, эрүүл зөв хооллолт, аюулгүй хүнсний хэрэглээг төлөвшүүлэх, залуучуудын чөлөөт цагийг зөв, боловсон өнгөрүүлэх зорилгоор “Сүүтэй бялуутай үдэш” аяны нээлтийн ажиллагааг 2014 оны 10-р сард Цамбагаравын “Рокси” диско бааранд зохион байгуулж, дүүргийн удирдлагууд, Мандах бүртгэл дээд</p>	52.5

			<p>сургуулийн 63 оюутан, багш нар оролцлоо Аяны нэрэмжит шилжин явах тугийг аж ахуйн нэгж, байгууллагуудад аялуулан, “Ерөөгдсөн гэр бүл” ТББ-тай хамтран вакумжуулсан сургалт зохион байгуулсан. “Согтууруулах ундааны хяналтын тухай хууль”-ийн нээлттэй хэлэлцүүлэгт 130 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагууд, 210 орчим иргэдийг хамруулан 2014, 2015 онд 2 удаа зохион байгуулав. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/374, 2015 оны А/462, А/463 дугаар захирамжаар ГХУСА33, Цагдаагийн 1, 2, 3-р хэлтэстэй хамтран, 32 хорооны 223 чиглэлд 520 орчим төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэдийг эргүүлд гаргаж, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэн, нийт 138 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 35 аж ахуйн нэгж, байгууллага, 107 иргэнийг холбогдох хууль, тогтоомжийн 690.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.</p>	
84.	5.9. Замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, автын осол, түүнээс учрах хохирлыг бууруулна.	ЗЦТ	<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн шаардлагатай байршлуудад хурд сааруулагч 90, анхааруулах тэмдэг 20, мэдээлэх тэмдэг 52, бусад 203, нийт 365 орчим замын тэмдэг, тэмдэглэгээг хийсэн. 34-р байрны хойд замаас 32-р байрны уулзвар хүртэл зорчих хэсгийн голын үргэлжилсэн тэмдэглэлийн дагуу Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлээр 150 метр хайс суурилуулсан. Ерөнхий боловсролын 15 сургуулийн 16 байршилд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иж бүрэн тэмдэг, тэмдэглэл, стандартын шаардлага хангасан хурд сааруулагчийг холбогдох байгууллагуудаар хийж гүйцэтгүүлсэн. Сургуулийн өмнөх насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх зорилгоор 2013-2015 онд “Замын хөдөлгөөний цагаан толгой, “Ногоон гэрэл-Цагаан шугам” уламжлалт тэмцээнийг 32 цэцэрлэгийн 536 хүүхэд багачууд, Ерөнхий боловсролын 22 сургуулийн 930 сурагчдын дунд зохион байгуулж, ТВ-25, ТВ-5, SBN телевиз, хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр тэмцээний ач холбогдлыг олон нийтэд сурталчилсан. Дүүргийн нутаг дэвсгэрийн “Мандах бүртгэл”, “Ач”, “Монос” дээд сургууль, “Чингис соосэ” цогцолбор их сургуулийн 1-р курсийн 828 оюутан сурагчдад “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт сургалт хийж, сургалтын албыг сургалтын программ, гарын авлага материалаар хангасан.</p> <p>Хамгаалах бус, малгай, хүүхдийн хамгаалалтын суудлын ач холбогдол, согтууруулах ундааны хор уршиг, хурд хэтрүүлэх, уур бухимдлын хор</p>	75.0



			<p>уршгийн талаар 8 төрлийн тараах материал, санамж, богино хэмжээний шторк бэлтгэн тус тасгаар үйлчлүүлж байгаа иргэд, жолооч нарт тараан, дүүргийн ЗДТГ, ЗЦТ-ийн байрны хүлээлгийн танхимд байрлах дэлгэцээр шинэчлэн батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн талаар бэлтгэсэн шторкуудыг сурталчилж, Үндэсний олон нийтийн радиогийн “Тэнхлэг” шууд нэвтрүүлгээр дүүргийн замын хөдөлгөөний онцлог, нөхцөл байдал, хууль тогтоомжуудын талаар мэдээлэл хийж ажиллав. 1-р хороо Орбитын уулзварын хойд болон зүүн талд “Жолооны ард утсаар бүү ярь, бүү оролд”, “Хамгаалах бүс хэрэглэж хэвшье”, 8-р хороо Хувьсгалчдын гудамжинд “Бидний ирээдүй жолооч таны гарт байна, та хурдаа тохируул” бичээстэй 2 талтай 3 ширхэг самбарыг тус тус байрлуулсан. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийн мэдээлэл, хор уршиг, хот хооронд зорчиход анхаарах зүйлс, “Нийтийн тээвэр”, “Автобусны зогсоол”, “Сар шинэ”, “Согтуу”, нэгдсэн арга хэмжээний талаар SBN, Royal HD, ТВ-5, Royal HD телевизүүдээр мэдээлэл өгч, <a href="http://www.medee.mn">www.medee.mn</a>, <a href="http://www.news.mn">www.news.mn</a>, <a href="http://www.zaluu.com">www.zaluu.com</a> мэдээллийн сайтуудад байршуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн хэрэг 2013 онд 1050, 2014 онд 947, 2015 онд 673, ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо 2013 онд 38, 2014 онд 37, 2015 онд 25 гарсан байна. Осол, хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байна.</p>	
85.	<p>5.10. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учрах хохирлыг бууруулна.</p>	ОБХ	<p>Батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу дүүргийн төрийн болон хувийн хэвшлийн 254 байгууллагын 8471 ажилтан албан хаагчид, 24387 оюутан сурагчид оролцсон 231 удаагийн 482 цагийн сургалтад 42363 хүн хамрагдан, 13051 иргэнд 5 төрлийн 31620 ширхэг гарын авлага, сэрэмжлүүлэх материал тараасан байна. Дүүргийн Засаг даргын А/71 дүгээр захирамжаар дүүргийн Гамшгаас хамгаалах албадыг байгууллаа. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтыг 2014 оны 04-р сард зохион байгуулж нийслэлийн Онцгой байдлын газраас бүрэн хангалттай дүгнэгдсэн. Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран 2015 оны 10-р сард дүүргийн нутаг дэвсгэрийн 100 аж ахуйн нэгж байгууллагад Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад ерөнхий үнэлгээгээр 82.1 хувь буюу “В” үнэлгээтэй дүгнэгдсэн. Дүүргийн өмч, газрын харилцааны албатай хамтран яаралтай дуудлагын авто машин хүрэлцэн очих боломжгүй 3 гудамжны орц, гарцыг чөлөөлж, үерийн аманд болон өндөр хүчдэлийн шугамын ойр орчимд зөвшөөрөлгүй буусан 1042 айл өрхөд албан шаардлага хүргүүлэн, 58</p>	67.5

			айлыг албадан нүүлгэсэн. Дүүргийн Засаг даргын нөөц сангаас гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх ажилд нийт 9.9 сая төгрөгийн техник, хэрэгслийг хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн. Тохиолдож болзошгүй байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, тэжээвэр болон зэрлэг мал, амьтан, ургамлын гоц халдварт өвчнөөс хүн болон хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу зохион байгуулж гүйцэтгэх үед мөрдөн ажиллах загвар төлөвлөгөөг 32 хороо тус бүрт хүргүүлэв. Дүүргийн Гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөө, 32 хороодын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулсан.	
86.	5.11. Аж ахуйн нэгж, байгууллагад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтыг сайжруулах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.	МХХ	“Барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 35 барилгад хяналт хийж 89 зөрчил илрүүлж 31 зөрчлийг газар дээр нь арилгуулж, аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй 6 барилгын үйл ажиллагааг түр зогсоож, 10 аж ахуйн нэгжид 53 заалттай 10 албан шаардлага хүргүүлж, зөвлөгөө өгч ажиллалаа. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэл явуулдаг 6 аж ахуйн нэгжийн 25 нэгж, объектод хяналт хийлээ. Шалгалтаар “Хөдөлмөрийн тухай хууль”, дүрэм заавар биелүүлээгүй 25 зөрчил, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль”, хөдөлмөр хамгааллын стандарт, дүрэм, журам, зааврыг биелүүлээгүй 58 зөрчил, нийт 83 зөрчил илрүүлсний 58 зөрчлийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар 25 заалттай 3 хамтарсан албан шаардлагыг “Хос гол” ХХК, “ Капитал фактори” ХХК, “Буян холдинг” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн. Мөн хөдөлмөрийн харилцааны талаархи эрхзүйн бичиг баримтыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан мөрдөх талаар 6 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлэн ажилласан. 13 ослын материал хүлээн авч, үйлдвэрлэлийн ослын акт тогтоон баталгаажуулж 18 аж ахуйн нэгжид тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны гэрчилгээ олголоо. 100 гаруй ААНБ-д “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, тогтоомжийн биелэлтийг шалгасан байна. Шалгалтанд барилга угсралтын 34, барилгын материалын үйлдвэр 25, хүнсний үйлдвэр 12, зам барилгын 3, бусад орон сууцны үйлчилгээний 6 салбар хамрагдсан байна. Дүүргийн Засаг даргын 2014 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/87 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан нийслэлийн ИТХ-ын	67.5

			Тэргүүлэгчдийн 2013 оны 75 дугаар тогтоолоор баталсан “Барилга угсралтын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах асуудлыг зохицуулах нийтлэг журам”-ыг хэрэгжилтийг хангуулахаар 22 барилгын нэгж объектод хяналт шалгалтыг хийсэн байна. Шалгалтын явцад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахтай холбоотой 300 гаруй зөрчил илрүүлж, 22 албан шаардлага бичиж, 7 ААНБ-ын үйл ажиллагааг түр хугацаагаар хэсэгчлэн зогсоож, 18 ААНБ-д 7190.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч, нийт 44 ААНБ-д зөвлөмж боловсруулан хүргүүлсэн байна.	
87.	5.12. Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтэнд хяналт тавин иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэнэ.	ЦШ	“Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2013, 2014, 2015 оны цэргийн бүртгэлийг дүүргийн Засаг даргын 2012 оны 381, 2013 оны 490, 2014 оны А/468 дүгээр захирамжийн дагуу 2013 оны 1 дүгээр сарын 4-21-нд 94,8 хувьтай, 2014 оны 1 дүгээр сарын 06-20-ны өдрүүдэд 92.8 хувьтай 2015 оны 01 дүгээр сарын 05-20-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж явуулсан. 2013, 2014 2015 онд дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, 18-50 насны эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн биелэлтийг шалган туслах ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 36 аж ахуй нэгж, байгууллагад зохион байгуулж явуулсан. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 92, 93 94 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бодлого үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-эх оронч үзэл, бахархал төлөвшүүлэх “Бид эх орны ирээдүй” сэдэвт уулзалт ярилцлага, цэрэг спортын “Дөл” тоглолт, “Иргэн цэргийн бахархал” сэдэвт зохион бичлэгийн уралдаан, “Цэргийн штаб”-ын нэрэмжит өсвөр үеийн “Үндэсний бөхийн” барилдаан, “Цэргийн алдар” спорт тэмцээн, “Иргэн цэргийн бахархалын өдөр” цэрэг, урлаг соёлын баярын цэнгүүний арга хэмжээ, Соёлын төв өргөөнд зохион байгуулагдсан “Бидний ажил” сэдэвт нийслэл, дүүргүүдийн Цэргийн штабуудын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд ажлаа танилцуулах өдөрлөг, Халх голын байлдааны ялалтын 75 жил, Чөлөөлөх дайны ялалтын 70 жилийн ойн арга хэмжээг тус тус зохион байгуулж явуулав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2013, 2014, 2015 оны “Сургалт зохион байгуулах тухай” тушаалын дагуу дайчилгааны бэлтгэл нөөц, цэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн бага мэргэжил олгох сургалтыг 2013, 2014, 2015 онд Батлан хамгаалах их сургууль, Зэвсэгт хүчний 119, 011 дүгээр ангийн сургалтын төвд зохион байгуулсан. Батлан хамгаалах	75.0

		<p>их сургуулийн Цэргийн командын сургуулийн сургалтын материаллаг баазыг түшиглэн Бэлтгэл офицерын сургалт 2013, 2014, 2015 онд зохион байгуулагдаж явагдсан.</p> <p>Цэргийн штабын 2013, 2014 2015 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Цугларах, шилжүүлэх байр, Дайчилгаа удирдах бүлгийн томилгоот бүрэлдэхүүнтэй мэдлэг дадлага олгох сургалтыг зохион байгуулж явуулсан. Дүүргийн Засаг даргын захирамжаар хорооны Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалт 2013, 2014, 2015 онд Зэвсэгт хүчний 311 дугаар анги, Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн байрлалд зохион байгуулагдаж явагдав. Нийслэлийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын тушаал, дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын анхан шатны сургалт Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангийн байрлалд 2013, 2014 2015 онд зохион байгуулагдаж явагдав. Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан хуваарь, дүүргийн Засаг даргын захирамжийг тус тус үндэслэн цэргийн дүйцүүлэх алба хаагчдын гүйцэтгэх үүргийн мэдлэг дадлагыг гүнзгийрүүлэх сургалтыг 2013, 2014, 2015 онд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай ангийн байрлалд зохион байгуулж явуулсан. Дайчилгааны тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан дүүргүүдийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтад албан тушаалтнуудыг хамруулсан. Нийслэлийн Засаг даргын 2013 оны а/347, а/872, 2014 оны а/259, а/774, 2015 оны А/235, А/753 дүүргийн Засаг даргын 2013 оны 143, 399, 2014 оны а/116, а/345, 2015 оны А/110, А/397 дугаар захирамжуудын дагуу 2013, 2014, 2015 оны 1, 2 дугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны халалт, татлага, гэрээт цэргийн албанд иргэдийг элсүүлэх ажлыг 2013 оны 05 дугаар сарын 03-05, 10 дугаар сарын 18-20, 2014 оны 05 дугаар сарын 09-11, 10 дугаар сарын 17-19, 2015 оны 05 дугаар сарын 08-10, 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн тоон даалгаврыг бүрэн биелүүллээ.</p> <p>2013, 2014, 2015 онд Дайчилгааны даалгавартай анги, байгууллагуудтай 6 удаа тодотгол явуулж, оногдуулан данслагдсан бэлтгэл офицер, цэргийн үүрэгтэнийг тодотгон, 2014, 2015 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан дайчилгаатай команд штабын хээрийн сургуульд амжилттай оролцож, тавигдсан үүргийг бүрэн ханган биелүүлсэн. 2013- 2015 онд Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол</p>	
--	--	---	--

			хангасан 872 иргэнээр 383,8 сая төгрөгийн мөнгөн төлбөр төлүүлж нийслэлийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэв. 2013, 2014, 2015 онд Цэргийн тоо бүртгэлээс хоцорсон, цэргийн жинхэнэ албан татлагаар ирээгүй 1435 иргэнд хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авч 26,1 сая төгрөгийн торгууль оногдуулан дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дансанд төвлөрүүлсэн.	
88.	5.13. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлж, өндөр хөгжилтэй орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтоон, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг татаж ажиллана.	ЗХХ	2013 онд харилцаа хамтын ажиллагаатай БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хайлаар хот, БНСУ-ын Сөүл хотын Сеонбуг дүүрэг, Тэжон хотын Сео дүүргүүдийн зүгээс 4 удаагийн айлчлалыг хүлээн авч, дээрх хот, дүүргүүдэд 5 удаагийн айлчлал, туршлага судлах аяллыг хийж хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны төлөвлөгөө, чиглэл, хийж хэрэгжүүлэх ажлуудын талаар хэлэлцсэн. 2014 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган аймгийн Рашаан хот, 2015 онд Япон улсын Шизүока мужийн Изүнокүни хоттой шинээр харилцаа тогтоон хамтын ажиллагаа эхлүүлээ. “Эрүүл мэндийн суварга” байгууллагатай хамтран БНСУ-ын Чунь - Ань их сургуулийн эмнэлэг, Чейл эмэгтэйчүүдийн эмнэлэгт дүүргийн ЭМТ-ийн 20 эмчийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. 2014 оны 2-р сард дүүргийн Засаг дарга БНСУ-ын “Самдунг интернэйшнл” ТББ-тай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсны дагуу “Самдунг интернэйшнл” ТББ нь дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт нэг ээлжиндээ 200 хүний сургалтын хүчин чадал бүхий МСҮТ байгуулсан. БНСУ-ын “Эмч нарын сайн дурын сан” ТББ-тай хатран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааны хүрээнд 2014, 2015 оны 6-р сард БНСУ-ын шүдний эмч нарын баг дүүргийн иргэдэд эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн байна.	52.5
89.	5.14. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ХЭАХН, ШӨХТГ-тай хамтран ажиллана.	ЗХХ, ХЭАХН	Дүүргийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажилтай холбогдуулан 2013 онд 4042,5 мян төгрөгийн санхүүжилт өгч, ХЭАХН-ийн ажлын өрөөг 18-р хорооны хуучин байранд шинээр тохижуулан ашиглаж байна. Хэрэглэгчийн эрх хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2013 оны 2/82 албан даалгаврыг аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. ШӨХТГ, "ШУТИС-ийн Шим тэжээл судлалын төв, дүүргийн ЭМН, “Өнөр” бүсийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”, “Зохистой хоол-эрүүл мэнд”, “Эрүүл аюулгүй хүнс-жирэмсэн эмэгтэйчүүдийн хооллолт”, сэдэвт өдөрлөг болон ХЭАХ нийгэмлэгүүдийг сурталчилах арга хэмжээнд 1000 гаруй иргэдийг хамруулж, үйл ажиллагаагаа сурталчлав. Хэрэглэгчийн эрх зөрчигдсөн тухай бичгээр 7, утсаар 59 гомдол ирүүлсэний дагуу 20 гаруй байгууллагаар	52.5

			<p>хяналт, шалгалт хийж, 4 хэрэглэгчийн 630,0 мянган төгрөгийн хохиролыг шүүхийн өмнөх шатанд нь барагдуулав. Олон улсын Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах байгууллагаас дэвшүүлсэн “Эрүүл зөв хооллолт”-ын тухай үндсэн ойлголт, ач холбогдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэн, “Хүн бүр хооллолтын зөв дадал хэвшил эзэмшиж, эрүүл бие саруул ухаантай байцгаая” уриалгатай холбогдсон цуврал зөвлөмж, мэдээллүүдийг “Сонгинохайрхан” сонин, <a href="http://www.hereglegch.plm.mn">www.hereglegch plm.mn</a> цахим хуудсанд байршуулсан. Үсчин гоо сайхан, гар утасны худалдаа, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хүнсний бөөний захуудад хяналт тандалтын ажлыг хийж, хэрэглэгчдийн саналыг авч, холбогдох байгууллагуудад зөвлөмж, саналуудыг хүргүүлсэн.</p>	
--	--	--	--	--

---000---